УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24-201
2024.01.08

Захиалагч:	УИХ-ын дэд дарга Д.Мөнхбаатар
Хянасан:	Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа
Хянасан:	Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Ц.Норовдондог
Судлаачид:	ЭШАА О.Билгүүтэй Референт Р.Оргилмаа Референт Д.Жигваагүнсэл ЭША Т.Эрдэнэчимэг ЭША Б.Баянмөнх ЭША Х.Очир

УЛААНБААТАР
2024 ОН

ГАРЧИГ

УДИРТГАЛ 2
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ХЭСЭГ 3
СУДАЛГААНЫ ХЭСЭГ 13
НЭГ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАТ НУТГИЙН ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ ТОДОРХОЙЛОЛТ- НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ 13
ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА 16
БНСУ 16
АВСТРАЛИ УЛС 23
ФИЛИППИН УЛС 28
ОХУ 36
БНХАУ 38
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ 42

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын дэд дарга Д.Мөнхбаатараас 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн УИХ-02/10215 дугаар албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу “Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалт гадаадын зарим орны туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго

Тухайн асуудлаар сайн туршлагатай гэж үзсэн зарим орны тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, ашиглалтын талаарх эрх зүйн орчин, тусгайлсан зохицуулалт мөн тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөгддөг ах ахуйн үйл ажиллагааны талаар судлах.

Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд *Нэгдсэн Үндэстний Байгууллагын Биологийн олон янз байдлын тухай конвенц* (CBD) болон *Олон улсын байгаль хамгаалах холбоо* (IUCN)-оос гаргасан тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхойлолт, зөвлөмжүүд болон гадаадын зарим улс болох БНСУ, Австрали, Филиппин, ОХУ, БНХАУ зэрэг гадаадын зарим улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчин, зохицуулалттай холбоотой мэдээллийг бэлтгэв.

Судалгааны тайлангийн бүтэц:

Судалгаа нь 2 хэсэгтэй. *Нэгдүгээр хэсэгт*: Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх олон улсын байгууллагуудын, тодорхойлолт *Нэгдсэн Үндэстний Байгууллагын Биологийн олон янз байдлын тухай конвенц* (CBD) болон *Олон улсын байгаль хамгаалах холбоо* (IUCN)-оос гаргасан зөвлөмж, олон улсын туршлага; *Хоёрдугаар хэсэгт*: БНСУ, Австрали, Филиппин, ОХУ, БНХАУ-ын Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчин, тусгайлсан зохицуулалттай холбоотой асуудлуудыг судалсан болно.

Түлхүүр үг: Тусгай хамгаалалттай газар нутгийн зохицуулалт, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн хамгаалалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого

Keyword: Protected area regulation, National park conservation, Protected area policy

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ХЭСЭГ

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай асуудал нь дэлхий нийтийн байгаль хамгаалах стратегид гол байр суурь эзэлдэг байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн эдийн засгийн үр ашиг нь үзэсгэлэнт онгон дагшин байгаль, зэрлэг ан амьтад болон нутгийн өвөрмөц соёлоос шууд хамаарч байдаг нь эдгээр хүчин зүйлсийг хамгаалалтад авах нэгэн том шалтгаан болдог.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагаас үзэхэд, тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчин, үйл ажиллагааны хувьд ижил төстэй талууд нэлээд ажиглагдаж байна. Тухайлбал, тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, ашиглах, менежментийн болон бодлого, зохицуулалтын асуудал нь ихэвчлэн байгаль орчин хариуцсан яамдын эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдаж байна. Гэвч зарим тохиолдолд үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, үүнд хамаарал бүхий байгууллагууд хамтран, тусгай хамгаалалттай газрын менежмент, зохион байгуулалт, арчилгаа, үйлчилгээ зэрэг үйл ажиллагааг хариуцан ажилладаг туршлага ч байна. Эрх зүйн орчны хувьд тухайн асуудалд хамаарал бүхий хэд хэдэн хуулиудаар зохицуулагдаж байна. Тухайлбал Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгалийн цогцолборт газрыг хамгаалах тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль гэх мэтийн нийтлэг зохицуулалтын хуулиудаас гадна Тусгай хамгаалалттай газрыг хамгаалах тухай бие даасан, тусгайлсан хуулиар зохицуулдаг орон ч байна.

Эрх зүйн орчны хүрээнд нийтлэг ажиглагдаж байгаа зохицуулалт гэвэл, ихэнх орнуудад аливаа онгон зэрлэг шим мандлыг сүйтгэх, устгах, бохирдуулах, зэрлэг ховор ан амьтан агнах, хил хязгаарыг нь эвдэж сүйтгэх, зам гарцыг гэмтээх, тэсэлгээний бодис ашиглах, барилга байгууламж барих, хайгуул, малтлага хийх, зэргийг хуулиар хатуу хориглож байна. Харин тусгай хамгаалалт бүхий газар менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан барилга байгууламжийг тодорхой хяналт, зөвшөөрөлтэйгөөр барих, судалгаа шинжилгээ, шинжлэх ухааны ажиглалт хийх, сургалтын дадлага хийх, тухайн бүс нутагтай танилцах зорилго бүхий, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах, үнэт болон ховордсон ан амьтан, зэрлэг ургамлын төрөл зүйлийг гаршуулах, үржүүлэх зэрэг үйл ажиллагааг тодорхой зөвшөөрөлтэйгөөр явуулахыг зөвшөөрдөг байна.

Австрали

Австрали Улсын нийт газар нутгийн 22.1 хувь буюу 169.9 сая га талбайг хамарсан 13903 тусгай хамгаалалттай газар нутаг байна. Австрали Улсын Хүрээлэн буй орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах тухай хууль (Environment Protection and Biodiversity Conservation Act 1999)[1] хууль болон түүнийг хэрэгжүүлэх журам[2] нь тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах гол эрх зүйн акт бөгөөд энэхүү хуулиар зөвхөн Австрали төдийгүй олон улсын хэмжээнд ховор, чухал ач холбогдолтой ургамал, амьтан, газар нутгийг хэрхэн хамгаалах, ашиглах зохицуулалтыг хийсэн байна. Австрали

[1] https://www.legislation.gov.au/Details/C2023C00225
[2] https://www6.austlii.edu.au/cgi-bin/viewdb/au/legis/cth/consol_reg/epabcr2000697/

Улс нь 1992 онд батлагдсан Биологийн олон янз байдлыг хамгаалах тухай конвенцод нэгдэн орсныхоо дагуу Австрали Улсын Үндэсний байгаль хамгаалах, хадгалах тогтолцоо (National Reserve System)[3]-г үүсгэн бий болгосон байна. Энэ нь тус улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ бөгөөд хойч үедээ байгалийн үзэсгэлэнт газар, ургамал, амьтдаа өвлүүлэн үлдээх зорилготой. Тус улсад тусгай хамгаалалттай газар нутагт ноцтой нөлөө, хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулахыг хориглодог бөгөөд Хамтын нөхөрлөлийн Байгаль орчны сайд нь байгаль орчны үнэлгээ болон стратегийн үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийсний үндсэн дээр үйл ажиллагааны зөвшөөрлийг олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгосон аялал жуулчлал, амралт сувиллын үйл ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангахын сацуу нийгмийн томоохон асуудал болох иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зэрэг нийгмийн хариуцлагын чухал чухал шаардлагууд тавигддагаараа онцлогтой байна.

Филиппин

Филиппин улс нь тусгай хамгаалалттай газар нутгийн хадгалалт, хамгаалалт, эрх зүйн зохицуулалтаараа дэлхийд сайн туршлагатай орнуудын нэгд тооцогддог. Филиппин улсын туршлагаас авч үзвэл, тус улс нь байгалийн нөөц, баялаг, үзэсгэлэнт ховор байгалийн онгон дагшин төрх байдлыг хамгаалах ажлыг эрчимтэй зохион байгуулсан гэж хэлж болно. 1990-ээд оноос байгалийн олон янз байдлыг ангилал бүрээр нь бүртгэлжүүлэх, байгаль хамгаалах үндэсний нэгдсэн сүлжээг бий болгох ажлыг эхлүүлсэн төдийгүй тусгай хамгаалалттай газар нутгийн харилцааг зохицуулсан бие даасан хууль (Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны тухай хууль) батлан хэрэгжүүлж эхэлсэн байна. Ингэснээр шинээр тусгай хамгаалалттай газар нутгийг тогтоон байгуулах, төрөл зүйлийг нэмэгдүүлэх, байгалийн унаган төрхийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлжээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагааг Байгаль орчин, байгалийн нөөцийн газар, Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдах зөвлөл зэрэг байгууллагууд удирдах бөгөөд эдгээр байгууллагууд нь өөрийн салбар нэгжээрээ дамжуулан тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг нь аль болох алдагдуулахгүй байх бүх нөхцөл байдлыг хуулийн хүрээнд бүрдүүлж, хяналт тавьж ажиллана. Хуульд тусгай хамгаалалттай газар нутагт тэр дундаа байгалийн дархан цаазат газар, ан амьтан, ус, ургамал, уугуул иргэдийн оршин суух газар нутаг, зан үйл, соёлд хор хөнөөл учруулах үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглодог. Тухайлбал, аливаа зэрлэг ан, амьтдыг агнах, устгах, үргээх, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүнийг агнах, авах, түүх, цуглуулах, эзэмших, сүйтгэх, устгах, бохирдуулах, агнах, хил хязгаарыг нь эвдэж сүйтгэх, зам гарцыг гэмтээх, тэсэлгээний бодис ашиглах, барилга байгууламж барих, хайгуул, малтлага хийх, аливаа нийтийн эзэмшлийн газрыг эзэмшихийг хориглоно.

[3] https://www.dcceew.gov.au/environment/land/nrs#daff-page-main

Дархан цаазат газар нутгаас бусад тусгай хамгаалалттай газар нутагт тодорхой судалгаа, шинжилгээ болон байгаль хамгаалах зорилгоор, мөн байгаль орчны үнэлгээгээр зөвшөөрөгдсөн зарим үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө.

БНХАУ

БНХАУ-д нийт 11800 гаруй тусгай хамгаалалттай газар байх бөгөөд энэ нь тус улсын нийт газар нутгийн 18%-ийг эзэлдэг байна. Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн нөөц газар, ойн бүс газар, байгалийн үзэмжит газар, үндэсний цэцэрлэгт хүрээлэн, цэвэр усны нөөцийн тусгай хамгаалалттай газар, далайн эргийн тусгай хамгаалалттай газар зэрэг газрууд хамаардаг байна. БНХАУ-ын тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах стратегийн зорилго нь байгалийн унаган төрх байдал, эко систем болон биологийн олон төрөл зүйлийн ургамал, зэрлэг амьтад зэргийг хамгаалахаас гадна тухайн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих явдал юм. БНХАУ-д улсад 300 гаруй зэрлэг амьтан, 130 гаруй зэрлэг ургамал тусгай хамгаалалтад байдаг байна. БНХАУ-д тусгай хамгаалалттай газар нутгийг БНХАУ-ын Үндсэн хууль, БНХАУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БНХАУ-ын Байгалийн нөөц газрын тухай журам болон бусад холбогдох хуулиудаар зохицуулдаг. БНХАУ-ын тусгай хамгаалалттай газар нутаг, түүнд холбогдох асуудлыг хариуцсан төрийн дээд байгууллага нь БНХАУ-ын Экологи, Байгаль орчны яам байна. БНХАУ-ын Экологи, Байгаль орчны яам нь тус улсын Төрийн Зөвлөлийн харьяа экологи, байгаль орчны асуудлыг хариуцдаг гүйцэтгэх засаглалын байгууллага юм. Тусгай хамгаалалттай газрыг БНХАУ-ын Байгалийн нөөц газрын тухай журамд зааснаар үндсэн бүс, хамгаалалтын бүс, туршилтын бүс гэж 3 ангилдаг байна. Тухайн 3 бүсэд зөвшөөрөгдөх үйл ажиллагаа харилцан адилгүй бөгөөд тухайлбал, үндсэн бүсэд тус журмын 27-р зүйлд заасан судалгаа, шинжилгээний ажлаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг. Хамгаалалтын бүс болон туршилтын бүсэд судалгаа хийх, шинжлэх ухааны туршилт явуулах, сургалтын дадлага хийх, тухайн бүс нутагтай танилцах, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах, үнэт болон ховордсон амьтан, зэрлэг ургамлын төрөл зүйлийг гаршуулах, үржүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг байна.

ОХУ

ОХУ-д анх Байгаль нуур орчмыг хамгаалах зорилгоор 1917 оны 1-р сарын 11-нд байгалийн нөөц газрын ангилал бий болгож, экосистемийг хамгаалж эхэлсэн гэж үздэг. Одоогийн байдлаар ОХУ-д 237 тусгай хамгаалалттай газар нутаг бүртгэгджээ. ОХУ-ын Тусгай хамгаалалттай байгалийн нутаг дэвсгэрийн тухай" Холбооны Улсын хуульд[4] зааснаар тусгай хамгаалалттай газар нутаг гэдэгт байгаль хамгаалах, шинжлэх ухаан, соёл боловсрол, аялал жуулчлал, эрүүл мэндийн ач холбогдол бүхий байгалийн цогцолбор газар нутаг болон усны гадаргуу, агаарын орон зайн хэсгийг оруулж тооцохоор тодорхойлсон

[4] https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_6072/

байна. Тусгай хамгаалалттай газар нутгийг Улсын байгалийн нөөц, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Дархан цаазат газар нутагт ангилж үздэг.

"Тусгай хамгаалалттай байгалийн нутаг дэвсгэрийн тухай" холбооны хууль нь 1995 онд батлагдсан. Тус хуулиар тусгай хамгаалалттай байгалийн нутаг дэвсгэрийг ашиглах, хамгаалах үзэл баримтлал, үндсэн зарчмууд, тогтолцооны байгууллагуудын өмчлөлийн хэлбэр, ОХУ-ын бүс нутгийн засаг захиргааны болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын бүрэн эрхийг тодорхойлсон. Тусгай хамгаалалттай газар нутагт биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах, байгаль орчны судалгаа хийх, боловсрол олгох, эдийн засгийн үр ашигтай байдлаар эргэлтэд оруулах хууль эрх зүйн зохицуулалт хийж өгсөн байдаг.[5]

ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яам нь тусгай хамгаалалттай газар нутгуудад үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, цуцлах, хуулиар тогтоосон хэм хэмжээг мөрдүүлэх ажлыг хариуцдаг. ОХУ-ын тусгай хамгаалалттай газар нутгийн ихэнх нь Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны тусгай хамгаалалттай газар нутгийн шалгуурыг хангадаг байна.

[5] http://government.ru/department/48/events/

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчин, зохицуулалтын зарим асуудлаарх харьцуулсан хүснэгт

Д/д	Улс	ТХГН-ын, эрх зүйн орчин	ТХГН-ийн хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	ТХГН-т хориглосон үйл ажиллагаа	ТХГН-т зөвшөөрсөн үйл ажиллагаа
1	БНСУ	- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (Natural Environment Conservation Act), - Байгалийн цогцолборт газрын тухай хууль (Natural Parks Act) - Далайн орчны менежментийн тухай хууль (Marine Environment Management Act), - Соёлын өмчийг хамгаалах тухай хууль (Cultural Property Protection Ac),	- Байгаль орчны яам (The Ministry of Environment) - БНСУ-ын Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн үйлчилгээ (Korea National Park Service)	Байгалийн цогцолборт газрын тухай хууль (Natural Parks Act) IV БҮЛЭГ Байгалийн Цогцолборт Газрын Хамгаалалт хэсгийн 23 дугаар зүйлд дараах үйлдлүүдийг хориглоно хэмээн заасан байдаг. -Барилга, бусад байгууламжийг шинээр барих, өргөтгөх, өөрчлөх, сэргээн босгох, буулгах, -Ашигт малтмал олборлох, шороо, чулуу, элс, дүүргэх, -Газар чөлөөлөх буюу газрын хэлбэр, чанарыг өөрчлөх (газар ухах, далайн ёроолын хэлбэр, чанарыг өөрчлөх зэрэг); -Ус зайлуулах замаар газрыг нөхөн сэргээх;	Байгаль орчныг хамгаалах хууль (Natural Environment Conservation Act) 13 дугаар зүйлд дараах тохиолдуудыг зөвшөөрдөг байна. - Тусгай хамгаалалт бүхий газар менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан барилга байгууламж, -Экологи, байгалийн үзэсгэлэнт газруудын экосистем, түүнийг хамгаалахад шаардлагатай ажиглалтын байгууламж, -Судалгаа шинжилгээ, шинжлэх ухааны ажиглалт, шинжилгээ хийх байгууламж, -Экологи, байгалийн үзэсгэлэнт газрыг хамгаалах, байгаль

				-Гол мөрөн, нуур, намаг, эрэг орчмын усны хэмжээ, түвшинг нэмэгдүүлэх, бууруулах; -Зэрлэг амьтан (далайн амьтдыг оролцуулан) барих; -Мод огтлох, зэрлэг ургамлыг түүж авах (далайн ургамал орно); -Гэрийн тэжээвэр амьтдыг салхилуулах; -Юм овоолох, уях; -Байгалийн цэцэрлэгт хүрээлэнгийн өнгө үзэмжийг алдагдуулах, хамгаалах, зохион байгуулахад саад учруулах	орчныг гадны этгээд халдахаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай гэж үзсэн байгууламж.
2	АВСТРАЛИ	- Хүрээлэн буй орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах тухай хууль (Environment Protection and Biodiversity Conservation Act 1999) - Хүрээлэн буй орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх журам (Environment Protection and	Цаг уурын өөрчлөлт, эрчим хүч, байгаль орчин, усны яам (Department of Climate Change, Energy, the Environment and Water)-ны харьяа холбогдох агентлагууд болон муж, орон нутгийн холбогдох албан байгууллагууд	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд зааснаас бусад дараах төрлийн үйл ажиллагааг хориглоно: • Тухайн газар нутгийн байгалийн ховор тогтцыг эвдэх, сүйтгэх;	Хуульд зааснаар тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөтэй нийцэж байгаа болон тухайн газар нутгийн удирдах газраас олгосон зөвшөөрлийн дагуу аялал жуулчлал, арилжааны зорилготой

		Biodiversity Conservation Regulation 2000) - Австралийн байгалийн нөөц, баялгийг хамгаалах 2009-2030 оны стратеги (Australia's Strategy for the National Reserve System 2009-2030)		• Биологийн төрөл зүйл, амьтан ургамлыг сүйтгэх; • Тухайн газар нутгийн түүх, соёлын дурсгалт өв, байгууламжийг эвдэх, сүйтгэх; • Тухайн газар нутагт амьдарч буй уугуул иргэдийн уламжлалт соёлын арга хэмжээнд хөндлөнгөөс оролцох, саад тотгор учруулах; Уугуул иргэдийн газар нутгаа хамгаалах уламжлалт ёс заншилд хөндлөнгөөс оролцох зэрэг болно.	кино зураг авалт болон гэрэл зураг авах, судалгаа, шинжилгээ хийх, түүнчлэн аливаа тэмдэглэлт арга хэмжээ зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа багтана.[6]
3	ФИЛИППИН	-Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны тухай хууль (7586 дугаар хууль, 1992 он); -Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн	-Байгаль орчин, байгалийн нөөцийн газар -Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдах зөвлөл	Тусгай хамгаалалттай газар нутагт **хориглох үйл ажиллагаанд** аливаа онгон зэрлэг шим мандлыг сүйтгэх, устгах, бохирдуулах, агнах, хил	**Тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн дархан цаазат газарт хориглосон үйл ажиллагаанаас бусад тохиолдолд** тусгай

[6] https://www6.austlii.edu.au/cgi-bin/viewdoc/au/legis/cth/consol_reg/epabcr2000697/s12.06.html

		тогтолцооны өргөтгөсөн хууль (11038 дугаар хууль, 2018 он).		хязгаарыг нь эвдэж сүйтгэх, зам гарцыг гэмтээх, тэсэлгээний бодис ашиглах, барилга байгууламж барих, хайгуул, малтлага хийх, аливаа нийтийн эзэмшлийн газрыг эзэмших зэрэг орно.	зориулалтын ашиглалтыг зөвшөөрч болно. Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдах зөвлөлөөс судалгаа, үнэлгээ хийсний үр дүнд байгаль орчны үнэлгээний шаардлагад нийцсэн төсөлд байгаль орчны нийцлийн зөвшөөрөл олгоно. Тухайн үйл ажиллагаа нь экосистемийн үйл ажиллагаа, биологийн олон янз байдал, соёлын зан үйл, уламжлалд хор хөнөөл учруулахгүй байх ёстой.
4	ОХУ	-Тусгай хамгаалалттай байгалийн газрын тухай холбооны хууль7 -ОХУ-ын Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Холбооны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу 33-FZ of 14.03.1995	-Засгийн газар -Байгалийн нөөц Экологийн яам	Тусгай хамгаалалтын дэглэмд харшлах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Тус бүс нутагт байгалийн олон янз байдалд нөлөөлөхүйц амьд организм нутагшуулах, барилга байгууламж барихыг хориглоно.Байгалийн нөөц	Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн өвөрмөц байдал, ургамал, амьтан, экологийн тогтолцоо, биологийн олон янз байдлыг байгалийн нөхцөлд хадгална. Мөн Тусгай хамгаалалттай газар нутагт шинжлэх

[7] https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_6072/

		-ОХУ-ын Засгийн газрын 2012 оны 03 дугаар сарын 03.03-ний өдрийн 297-р тогтоол		газрын зориулалтыг өөрчлөхийг хориглоно.	ухааны судалгаа хийх, сургалт явуулах, байгальд нөлөөлөх сөрөг үр дагаваргүй аялал жуулчлал эрхлэх, Байгалийн нөөц газарт амьдарч буй иргэдийн амьжиргааг хангах зорилгоор тариалалт хийхийг зөвшөөрнө.
5	БНХАУ	- БНХАУ-ын Үндсэн хууль, - БНХАУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хууль БНХАУ-ын Байгалийн нөөц газрын тухай журам	БНХАУ-ын Экологи, Байгаль орчны яам	Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагааг БНХАУ-ын Байгалийн нөөц газрын тухай журамд зааснаар: -Экосистемд нөлөөлөх нэн ховордсон амьтан, зэрлэг ургамлын зүйл бүртгэгдсэн нутаг дэвсгэрийг үндсэн бүсэд бүртгэж тухайн бүсэд ямар ч байгууллага, хувь хүнийг нэвтрэхийг хатуу хориглоно. Тус журмын 27 дугаар зүйлд заасан нөхцөл байдлаас бусад шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагаа явуулахыг хориглоно. -Бусад хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн тусгай үйл ажиллагаанаас бусад тохиолдолд мод огтлох, мал бэлчээх, ан агнах, загасчлах, ургамал түүх, тариалах, хээр газар өвс	Тусгай хамгаалалттай бүсэд судалгаа хийх, шинжлэх ухааны туршилт явуулах, сургалтын дадлага хийх, тухайн бүс нутагтай танилцах, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах, үнэт болон ховордсон амьтан, зэрлэг ургамлын төрөл зүйлийг гаршуулах, үржүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг байна.

				шатаах, олборлолт хийх, чулуу цуглуулах, элс ухах зэрэг үйл ажиллагааг хориглоно. Байгалийн нөөц газар болон тусгай хамгаалалтын бүсэд барилга байгууламж барихыг хориглоно.	

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАТ НУТГИЙН ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ ТОДОРХОЙЛОЛТ- НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD) нь олон улсын хэмжээнд биологийн олон янз байдлыг хамгаалах, амьтан ургамлын төрөл зүйлийн бүрэлдэхүүн, генетик нөөцийг тогтвортой ашиглах, үр ашгийг ижил тэнцүү хуваарилах үүднээс 1993 оны 12 дугаар сард хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхэлсэн.

Энэхүү конвенцид “**Тусгай хамгаалалттай газар нь байгаль орчныг хамгаалах тодорхой зорилгод хүрэх зорилгоор тодорхойлсон, тусгай зохицуулалт, удирдлагатай газар нутгийг хэлнэ**” гэж тодорхойлдог.[8]

Олон улсын байгаль хамгаалах холбоо нь (IUCN) байгаль орчин болон хөгжлийн сорилтуудад бодит шийдэл олоход олон улсад тусалдаг байгууллага юм. IUCN нь НҮБ болон хувийн хэвшил, төрийн болон ТББ-уудтай хамтран бодлого, хууль, эрхзүй, шилдэг туршлагуудыг боловсруулж байгаагаас гадна судалгаа шинжилгээ, дэлхий даяар хэрэгжиж буй олон төслүүдийг дэмжин ажилладаг.

Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN) нь тусгай хамгаалалттай газар нутгийг **"Байгаль орчныг урт удаан хугацаанд экосистемийнх нь үр ашиг, оршин буй соёлын үнэт зүйлсийнх нь хамт эрх зүй, бусад үр дүнтэй арга хэрэгсэл хэрэглэн хамгаалж, ашиглаж байгаа, хүлээн зөвшөөрөгдсөн газар зүйн орон зайг тусгай хамгаалалттай газар нутаг хэмээнэ"** гэж тодорхойлдог.[9]

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН АНГИЛАЛ

Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN) нь тусгай хамгаалалттай газрыг 6 үндсэн ангиллаар тодорхойлдог.

1.
    a. *Дархан цаазат газар*: Хуурай болон далайн бүсэд орших онцлог экосистем болон геологи/геоморфологи, биологийн олон янз байдал бүхий, аливаа ашиглалт нөлөөлөл нь хязгаарлагдсан, тусгай хамгаалалттай газар нутаг.
    b. *Зэрлэг онгон газар*: Биологийн олон янз байдал, түүний амьдрах орчин нь хүний үйл ажиллагааны нөлөөнд автаагүй, байгалийн унаган төрхийг нь хадгалах зорилготой бүс нутаг

[8] НҮБ-ийн Биологийн олон янз байдлын тухай конвенц. https://www.cbd.int/doc/legal/cbd-en.pdf
[9] Олон улсын байгаль хамгаалах холбоо, Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн ангиллыг хэрэглэх заавар. https://portals.iucn.org/library/sites/library/files/documents/pag-021.pdf

2. *Байгалийн цогцолборт газар*: Өөрийн гэсэн амьтан, ургамлын төрөл зүйл, экосистемийн онцлогтой, байгаль, соёлын өвийг хамгаалах хэмжээнд оюун санаа, шинжлэх ухаан, боловсролыг дэмжсэн үйл ажиллагаа, амралт зугаалга, аялал хийх боломжтой, экосистемийн баялаг процессыг хадгалж үлдсэн хөндөгдөөгүй, эсвэл бага хэмжээгээр хөндөгдсөн томоохон газар нутаг.
3. *Байгалийн дурсгалт газар*: Хуурай газрын тогтоц, тэнгисийн эрэг, далайн цүнхээл, агуй, балар эртний амьд ой гэх мэт. геологийн тогтцуудыг хадгалах зорилгоор хамгаалсан газар нутаг.
4. *Амьдрах орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн бүс нутаг*: Биологийн олон янз байдлын тодорхой зүйлийн амьтан ургамал, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах зорилгоор хамгаалалтад авсан газар нутаг. Хэдийгээр горимд нь тийм шаардлага үгүй ч олон тохиолдолд хөндлөнгөөс нь хүний интервенц хийж, тодорхой амьтан, ургамлыг хамгаалж байх шаардлагатай газар нутаг.
5. *Хуурай газар болон далай тэнгисийг хамгаалсан ТХГН*: Хуурай газар, далай тэнгис, эрэг орчмын нутгийг хамрах бөгөөд хүн байгалийн харилцан шүтэлцээнээс экологи, соёл, гоо зүйн чухал ач холбогдол бүрэлдсэн газар. Энэхүү харилцан шүтэлцээ нь тус газрын хадгалалт, тогтвортой байдал, байгаль хамгаалалтад чухал ач холбогдолтой болсон учир хамгаалалтад авсан газар нутаг.
6. *Байгалийн нөөцийг тогтвортой ашиглах ТХГН*: Экосистемийг уламжлалт ахуй соёл, байгалийн нөөц ашиглалтын уламжлалт менежменттэй нь цуг хадгалж, хамгаалдаг газар нутаг. Ихэвчлэн том хэмжээтэй, онгон байгалиа авч хоцорсон энэ газар нутгийн нөөцийг тогтвортой менежментээр дамжуулж ашигладаг бөгөөд байгаль хамгаалалд ноцтой хохирол учруулалгүйгээр, аж үйлдвэрийн бус хэлбэрээр нөөц ашиглалтыг зөвшөөрдөг газар нутаг.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН АШИГЛАЛТ

Олон улсын байгаль хамгаалах холбоо[10] (IUCN) болон *Дэлхийн байгаль хамгаалах сан*[11] (WWF) -с тусгай хамгаалалттай газрын ашиглалтын талаар хэд хэдэн эх сурвалжуудыг гаргасан байдаг. Дархан цаазат болон зэрлэг онгон газруудыг ашиглахыг хориглодог болов ч байгалийн цогцолборт газар болон түүнээс дооших ангиллуудыг тодорхой хэмжээнд ашиглахыг зөвшөөрдөг юм. Эдгээрээс үзэхэд тусгай хамгаалалттай газрын ашиглалтын хоёр ерөнхий төрөл харагдаж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ХУРААМЖ

[10] Олон улсын байгаль хамгаалах холбоо, Тусгай хамгаалалттай газар нутгийг санхүүжүүлэх нь: Тусгай хамгаалалттай газар нутгийн менежерүүдэд зориулсан зааварчилгаа. https://www.cbd.int/doc/nbsap/finance/IUCN-GuideFinancingPAs00.pdf

[11] Дэлхийн байгаль хамгаалах сан, Тусгай хамгаалалттай газруудын орлогыг нэмэгдүүлэх нь. https://www.cbd.int/doc/nbsap/finance/Spergel2001RaisRevPAs_RaisingRevPAs.pdf

"*Хэрэглэгчийн хураамжид*": нэвтрэх төлбөр; тусгай үзвэр үйлчилгээний төлбөр; зогсоол, хонох газар, аялал, зугаалга хийх байгууламжийн төлбөр; байр, хоол унд, хөтөч, усанд шумбах, загасчлах завь зэрэг үйл ажиллагаа явуулах концесс эзэмшигчдээс авах хураамж зэрэг зүйлс хэрэглэгчийн хураамжад орно. Хэрэглэгчийн хураамжаас олох боломжит орлого нь зочлолтын болон ашиглалтын түвшнээс хамаарч өөр өөр байдаг ч хураамж нь тухайн бүс нутгийн үйл ажиллагааны зардлын тал хүртэл хувийг хангах боломжтой.

Жишээлбэл, Балба улс Эверест болон Гималайн бусад оргилд гарахад хүний 11,000 ам.долларын хураамж авч жил бүр 2 сая гаруй ам.долларын орлого олдог. Танзани улсын тусгай хамгаалалттай газруудад зочлох гадаадын жуулчдаас тус тусад нь хонох газрын хураамж, түлээний хураамж, гэрэл зургийн хураамж төлөхөөс гадна өдөрт 25 ам. доллар төлөхийг шаарддаг.[12]

Хэрэглэгчийн хураамжийг тусгай хамгаалалттай газар нутгийн ажилтнууд эсвэл зочдод үйлчлэх эрх төдий концесс эзэмшигчид цуглуулах боломжтой. Хэрэглэгчийн хураамжийг тусгай хамгаалалттай газар нутгийн ажилтнууд авахын давуу тал нь тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтад ашиглагдах магадлал нь өндөр байдагт юм. Гэвч хураамж цуглуулах нь зардал шаарддаг бөгөөд төлбөр төлдөг олон үйлчилгээг үзүүлэхийн тулд мэргэжлийн ур чадвар шаардагдана. Тиймээс зарим улсад орлого нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй дуудлага худалдаагаар хамгийн өндөр үнэ санал болгосон этгээдэд концессын эрх олгох тогтолцоог баталсан.[13]

Заримдаа тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын агентлагууд нь өөрсдөө тусгай хамгаалалттай газар нутагт байрлах зочид буудал, зоогийн газар, дэлгүүр зэрэг зочдод зориулсан концессуудыг шууд эзэмшиж, ажиллуулдаг. Охайо мужийн байгалийн цогцолборт газрууд зуслангийн тоног төхөөрөмж, тэр байтугай амралт зугаалгын машин түрээслэх замаар мөнгө олдог бөгөөд энэ нь Охайо мужийн байгалийн цогцолборт газрын агентлагийн жилийн 21 сая долларын төсвийн 41 хувийг эзэлж байна.

ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

"*Түрээсийн гэрээ*" нь хувь хүн эсвэл хувь бүлэгт газар нутгийг тохиролцсон төлбөртэй, тодорхой хугацаагаар ашиглах боломжийг олгодог. IUCN-ны 2-6 дугаар ангилалтын газар нутгийг ашигт малтмал, газрын тосны хайгуул, ойн аж ахуйн үйл ажиллагаа, бэлчээрийн болон газар тариалангийн зориулалтаар түрээслүүлдэг. Энэ төрлийн орлого нь байгаль хамгаалах үндсэн зорилтуудтай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд маш болгоомжтой байх хэрэгтэй. Түрээслэх боломжтой бусад бага хохиролтой хэрэглээ бол унасан мод, гоёл чимэглэлийн ургамал, үр, жимс жимсгэнэ цуглуулах юм.

Жишээлбэл, АНУ-ын Мичиган муж төрийн өмчит газар нутгийн ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн нөөц олборлосны хураамжаар Байгалийн

[12] Дэлхийн байгаль хамгаалах сан, “Тусгай хамгаалалттай газар нутгийн орлогыг нэмэгдүүлэх нь” гарийн авлага, 14-р хуудас

[13] Дэлхийн байгаль хамгаалах сан, “Тусгай хамгаалалттай газар нутгийн орлогыг нэмэгдүүлэх нь” гарийн авлага, 14-р хуудас

нөөцийн санг санхүүжүүлдэг. Энэ сан нь сүүлийн 15 жилийн хугацаанд тусгай хамгаалалттай газар нутагт 300 гаруй сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлжээ. Норвеги, Филиппин зэрэг улсууд модны нөөц ашигласан концессын хураамж болгон засгийн газарт төлж буй мөнгөний тодорхой хувийг тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалтад зориулахыг шаарддаг. Намиби улс загасчлалын хөлөг онгоцнуудад хэдэн тонн загас барьснаас хамааран хураамж ногдуулдаг. Энэхүү хураамжийг загас агнуурын нөөцийг зохицуулах, загасчлахыг хориглодог тусгай хамгаалалттай газар нутгийн хэрэгжилтийг хангахад зарцуулдаг.[14]

Эм зүйн компаниуд халуун орны ширэнгэн ойд байдаг ургамлаас гаргаж авсан эмийн борлуулалтаас олон зуун сая долларын ашиг олсон. Эдгээр ургамлын зарим нь маш ховор бөгөөд зөвхөн тусгай хамгаалалттай газар нутагт байдаг. Филиппин, Фижи зэрэг улс орнууд байгууллагуудыг "био хайгуул" (эмийн зориулалтаар ашиглах боломжтой уугуул ургамлыг цуглуулах) эрхлэх зөвшөөрлийн төлбөр авах, арилжааны бүтээгдэхүүний борлуулалтын орлогоос төлбөр авах хууль баталсан.

Жишээлбэл, АНУ-ын Байгалийн цогцолборт газрын алба Йеллоустоун байгалийн цогцолборт газрын халуун рашаанаас олдсон микробын дээжийг цуглуулах эрхийг биотехнологийн компанид 100,000 ам. доллар болон ирээдүйн ашгийн тодорхой хувийн төлөө олгосон байна.

Африкийн олон улсууд спортын ан агнууraас ихээхэн орлого олдог. 2022 онд Танзани улс спортын ан агнууraас 25.1 сая ам.доллар, сафари салбараас бараг 116.8 сая ам.долларын орлого олжээ. Спортын ан агнуур, загасчлал нь шинжлэх ухааны үндэслэлтэй, хязгаарлалттай тохиолдолд л байгаль орчныг хамгаалах хэрэгсэл болж чадна.

Зарим тусгай хамгаалалттай газар нутгууд реклам сурталчилгаа, кино, зурагт хуудас болон бусад хэрэгцээнд ашиглах зорилгоор байгууллагуудаас “зар сурталчилгааны төлбөр” авч орлого олдог. Мөн нийтийн хэрэглээ, харилцаа холбоо, эрчим хүчний компаниудыг тусгай хамгаалалттай газар нутагт цахилгаан дамжуулах шугам, утасны шугам, радио телевизийн цамхаг, байгалийн хийн хоолой барих эрхийн төлөө олон сая доллар төлөхийг шаарддаг. Жишээлбэл, Китанглад уулын оргилын ойролцоох цахилгаан холбооны цамхгуудыг эзэмшдэг байгууллагууд өөрсдийн жилийн орлого дээр үндэслэн Филиппин Улсын засгийн газарт төлбөр төлдөг. Боливи Улсад олон тэрбум долларын өртөгтэй байгалийн хийн хоолой барихаар төлөвлөж буй олон улсын эрчим хүчний томоохон компани нь харьцангуй онгон дагшин газар нутгийг хамгаалах итгэлцлийн сан байгуулахын тулд 20 сая ам.доллар төлжээ.

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

БНСУ

БНСУ-ЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХЭМЖЭЭ

[14] Дэлхийн байгаль хамгаалах сан, “Тусгай хамгаалалттай газар нутгийн орлогыг нэмэгдүүлэх нь” гарийн авлага, 16-р хуудас

БНСУ-д бүртгэлтэй 1491 тусгай хамгаалалттай газар байна[15]. Хуурай газрын болон далай, гүний усыг хамарсан 100,148 км2 талбай байдаг ба энэ нь нийт газар нутгийн 18.5%-ыг эзэлдэг байна. Харин далайн эрэг ба тэнгисийн тусгай хамгаалалт бүхий газар нь 443,838 км2 буюу 1.4%-ыг эзэлдэг байна[16].

Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчин

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай эрх зүйн орчны үзэл баримтлалыг БНСУ-д 1960-аад онд Ойн тухай хууль, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн тухай хууль, Соёлын өмчийг хамгаалах тухай хуулиудыг бий болгосноор үндсэндээ бий болсон.

Хонгдо, Сеораксан уулыг 1965 онд, Жирисан уулыг 1967 онд анхны байгалийн дархан цаазат газраар бүртгэсэн. БНСУ-д тусгай хамгаалалттай газар нутгийн тухай холбогдох арав гаруй хууль байдаг. Эдгээр хуулиудаас Байгаль орчныг хамгаалах тухай хууль (Natural Environment Conservation Act), Далайн орчны менежментийн тухай хууль (Marine Environment Management Act), Соёлын өмчийг хамгаалах тухай хууль (Cultural Property Protection Ac), Байгалийн цогцолборт газрын тухай хууль (Natural Parks Act) байдаг ба эдгээр хуулиуд нь байгаль орчин, соёлын үнэт зүйлийг хамгаалах ерөнхий асуудлыг зохицуулдаг байна. Үлдсэн хуулиуд нь тусгай хамгаалалттай газар нутгийг тодорхойлох, удирдахад чиглэсэн зохицуулалтуудыг агуулсан байдаг. Дээрх хуулиудаас Тусгай хамгаалалттай газар, байгалийн цогцолборт газарт хэрхэн хүрээлэн буй орчныг хамгаалах, менежмент хийх талаарх зүйл заалтууд орсон байгааг тоймлон хүргэв.

Байгалийн цогцолборт газрын тухай хууль (Natural Parks Act)

Энэхүү хуулийн зорилго нь байгалийн цогцолборт газрын зориулалт, хамгаалалт, менежменттэй холбоотой зохицуулалтыг зааж өгөх замаар байгалийн экосистем, унаган төрх, соёлын үзэмж зэргийг хадгалах, тэдгээрийг зохистой ашиглах хамгаалах зорилготой болно. Энэхүү хууль нь 7 бүлэг 86 зүйлтэй байна.[17] Байгалийн цогцолборт газрын тухай хуульд хориглосон болон зөвшөөрөл авах шаардлагатай дараах заалтууд орсон байна. Үүнд IV БҮЛЭГ Байгалийн Цогцолборт Газрын Хамгаалалт хэсгийн 23 дугаар зүйлд дараах үйлдлүүдийг хориглоно хэмээн заасан байдаг.

- Барилга, бусад байгууламжийг шинээр барих, өргөтгөх, өөрчлөх, сэргээн босгох, буулгах,
- Ашигт малтмал олборлох, шороо, чулуу, элс, дүүргэх,
- Газар чөлөөлөх буюу газрын хэлбэр, чанарыг өөрчлөх (газар ухах, далайн ёроолын хэлбэр, чанарыг өөрчлөх зэрэг);
- Ус зайлуулах замаар газрыг өөрчлөх;

[15] https://www.protectedplanet.net/country/KOR
[16] https://www.env.go.jp/en/nature/asia-parks/pdf/wg3/APC_WG6-19_Sung-gon%20Kim.pdf
[17]БНСУ-ын Байгалийн цогцолбортгазрын тухай хууль https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=natural+park&x=0&y=0#liBgcolor1

- Гол мөрөн, нуур, намаг, эрэг орчмын усны хэмжээ, түвшинг нэмэгдүүлэх, бууруулах;
- Зэрлэг амьтан (далайн амьтдыг оролцуулан) барих;
- Мод огтлох, зэрлэг ургамлыг түүж авах (далайн ургамал орно);
- Гэрийн тэжээвэр амьтдыг салхилуулах;
- Юм овоолох, уях;
- Байгалийн цэцэрлэгт хүрээлэнгийн өнгө үзэмжийг алдагдуулах, хамгаалах, зохион байгуулахад саад учруулах

Мөн тус бүлгийн 27 дугаар зүйлд (2017 оны 12-р сарын 12-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан) дараах тохиолдуудыг онцгойлон хориглосон байдаг байна. Үүнд:

- Байгалийн цэцэрлэгт хүрээлэнд хохирол учруулах, сүйтгэх;
- Мод гэмтээх;
- Зэрлэг ан амьтдыг барихын тулд урхи тавих, хорт бодис, хөдөө аж ахуйн химийн бодисыг ашиглах;
- 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д заасны дагуу ан агнуурын буу ашиглах, зөвшөөрөл авалгүйгээр тор тавих;
- Хориглосон газар буудаллах;
- Хориглосон газар машин байрлуулах;
- Зориулалтын газраас гадуур хоол хийх ил гал гаргах;
- Зориулалтын газраас гадуур тамхи татах;
- Согтууруулах ундаа хэрэглэх;
- Хог, хаягдал гаргах, хаях, эвгүй үнэр гаргах зэргээр бусдад төвөг удах үйлдэл;

Зэрэг үйл ажиллагааг Байгалийн цогцолбор газарт явуулахыг хуулиар хориглодог байна.

Байгаль орчныг хамгаалах хууль (Natural Environment Conservation Act)

Энэхүү хуулийн зорилго нь байгаль орчныг хор хөнөөлөөс хамгаалах, байгалийн гамшигт үзэгдлээс хамгаалах, экосистем, байгалийн үзэмжийг хамгаалах, зүй зохистой менежмент хийх замаар байгалийн ая тухтай орчинд эрүүл саруул, амар тайван амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино. Байгаль орчныг хамгаалах хууль нь 2004 онд батлагдсан ба хамгийн сүүлд 2016 онд нэмэлт өөрчлөлт орсон байна. Нийт 7 бүлэг 66 зүйлтэй байна[18].

I БҮЛЭГ Ерөнхий үндэслэл

II БҮЛЭГ Экологи, байгаль хамгаалах бүсийн менежмент

III БҮЛЭГ Биологийн олон янз байдлыг хамгаалах

IV БҮЛЭГ Байгалийн нөөцийн менежмент

IV-2 БҮЛЭГ Байгалийн орчны нөхөн сэргээлтийн төсөл

V БҮЛЭГ Экосистемийг хамгаалах түүний төлбөр

[18] https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=37572&type=part&key=39

VI БҮЛЭГ Нэмэлт заалтууд

VII БҮЛЭГ Торгуулийн заалт

Тус хуулийн I БҮЛЭГ 17 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн зарлигаар цэргийн зориулалтаар үйл ажиллагаа явуулах, байгалийн гамшгийн улмаас яаралтай арга хэмжээ авахаас бусад тохиолдолд экологи, байгаль орчныг хамгаалах бүсэд дараах үйлдлүүдийг хуулиар хориглодог байна.

- Усны орчныг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан усны чанарт аюултай бодис хаях, хог хаягдлын хяналтын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан хортой хог хаягдал, Химийн бодисын хяналтын 2 дугаар зүйлд заасан хорт бодисыг хаях;
- Байгаль орчны яамны тушаалаар тодорхойлсон шатамхай бодис ашиглах, эсвэл Байгаль орчны сайдын тогтоосон газраас бусад газарт хоол хийх, ил гал гаргах буудаллах;
- Байгаль орчныг хамгаалахтай холбоотой тэмдэглэгээ болон бусад тэмдэглэгээг будах, гэмтээх, хөдөлгөх үйлдэл;
- Тусгай хамгаалалт бүхий үзэсгэлэнт газар өвс, мод бэлтгэх зэрэг бусад үйлдлүүд[19].

Мөн энэхүү байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлд дараах тохиолдуудыг зөвшөөрдөг байна.

- Хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тусгай хамгаалалт бүхий газар менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан барилга байгууламж,
- Экологи, байгалийн үзэсгэлэнт газруудын экосистем, түүнийг хамгаалахад шаардлагатай ажиглалтын байгууламж,
- Судалгаа шинжилгээ, шинжлэх ухааны ажиглалт, шинжилгээ хийх байгууламж,
- Экологи, байгалийн үзэсгэлэнт газрыг хамгаалах, байгаль орчныг гадны этгээд халдахаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай гэж үзсэн байгууламж.

Түүнчлэн байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дугаар зүйлд Залгаа бүсэд (Acts Allowed within Buffer Areas) дараах үйл ажиллагааг зөвшөөрдөг байна. Үүнд:

- Өдөр тутмын хэрэгцээний жижиглэнгийн дэлгүүр,
- Орчныг хамгаалах арчлах шаардлага бүхий байгууламж,
- Хоолны газар,
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуйн бүтээгдэхүүнийг хадгалах, байгууламж,
- Байгаль орчны талаар боловсрол олгох, олон нийттэй харилцах, судлах байгууламж, тухайлбал байгаль судлах төв, экологийн музей, ойн музей,

[19]https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=natural+park&x=0&y=0#liBgcolor1

модлог цэцэрлэгт хүрээлэн, ботаникийн цэцэрлэг, экологийн ой, экологийн судалгааны байгууллага.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд Шилжилтийн бүс нутагт (Transition Areas) дараах үйл ажиллагааг зөвшөөрдөг байна[20]. Үүнд:

- Шилжилтийн бүсэд зориулсан Байгаль орчны яамны тушаалаар тогтоосон нэгдүгээр зэрэглэл багтах барилга
- Эмнэлэг анхан шатны тусламж үзүүлэх байгууламж
- Малын саравч, тариалангийн саравч
- Амрах зугаалах хэсгийн ресторан, хүнсний газрууд
- Сургалтын байгууламжууд
- Тээврийн хэрэгсэл явган хүний зам, машин зам
- Усны байгууламж, ариутгах хэсэг, цахилгааны шон буюу нийтийн байгууламжууд зэрэг барилга байгууламжуудыг хуульд заасны дагуу яамнаас зөвшөөрөл авч стандарт тавигдах шаардлагын дагуу барьж болдог байна.

БНСУ-ЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН УДИРДЛАГА

БНСУ-ын Байгаль орчны яам (The Ministry of Environment) нь хүрээлэн буй орчин, байгаль орчны хамгаалалтай холбоотой асуудлуудыг ерөнхийд нь хариуцан ажилладаг ба БНСУ-ын Засгийн газрын шууд удирдлага дор ажиллагдаг. Байгаль орчны яам нь холбогдох хууль тогтоомж, журмуудын хэрэгжилтийг хангах, байгаль орчны судалгаа шинжилгээ хийх, ивээн тэтгэхээс гадна Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгүүдийг удирддаг. Доорх схемд БНСУ-ын тусгай хамгаалалттай газруудыг хариуцан ажиллах төрийн байгууллагуудыг үзүүлсэн бөгөөд тус тусын салбарын дагуу хариуцсан ажилладаг байна.

[20] https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=natural+park&x=0&y=0#liBgcolor0

Зураг 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлага



БНСУ-ЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙГ ХАРИУЦСАН БАЙДЛЫГ ЯАМДААР ТОГТООСОН БАЙДАЛ

Тусгай хамгаалалттай газар нутгийн ихэнх буюу 9,504.2 км2 газрыг БНСУ-ын Байгаль орчны яам хамгаалалтандаа аван хариуцан ажилладаг бол Далай тэнгис загас агнуурын яам 1,090 км2 талбайг, Соёлын өвийн газарт 828.8 км2 талбайг, Ойн газат 6.856.7 км 2 газрыг тус тус хариуцан хамгаалдаг байна.

Хүснэгт 2. Тусгай хамгаалалттай газар нутгийг хариуцсан яамд

Удирдлага	Бүртгэгдсэн газар	Хуурай газрын хэмжээ (Км2)	Далай тэнгис (Км2)
Байгаль орчны яам	700	9,504.2	3,265
Далай тэнгис, загас агнуурын яам	10	2,023.5	1,095.5
Соёлын өвийн газар	294	1,823.9	995

БНСУ-ын Ойн газар	463	6,856.7	0
Нийт	1467	20.208.3	5,351

БНСУ-ын Тусгай хамгаалалттай газар нутгийг Олон улсын конвенцоор тодорхойлсон байдал

Доорх БНСУ-ын Тусгай хамгаалалттай газрууд олон улсын конвенцод бүртгэгдсэн ба ЮНЕСКО-гийн Хүн ба шим мандлын хөтөлбөрт хамгийн их буюу 4 газар бүртгэгдсэн ба энэ нь 204.2 км2 газар байна.

Хүснэгт 3. Тусгай хамгаалалттай газар нутгийг Олон улсын конвенцоор тодорхойлсон байдал

Олон улсын конвенц	Бүртгэгдсэн газар	Хуурай газрын хэмжээ (Км2)	Далай тэнгис (Км2)
ЮНЕСКО-гийн Хүн ба шим мандлын хөтөлбөр (UNESCO MAB BR)	4	2042.2	451.1
Дэлхийн байгалийн өв (World Natural Heritage)	1	190	0
Рамсарын конвенц (Ramsar Convention)	17	176.8	163.5
Дэлхийн геопарк (Global Geoparks Network)	2	1992	55.1
Нийт	24	4401.3	669.7

БНСУ-ЫН ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (Korea National Park Service)

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн (KNPS) нь 1987 онд байгуулагдсан тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах удирдан зохион байгуулах, менежментийн мэргэжлийн байгууллага юм. Төв салбар нь Гангвон мужийн Вонжу хотод байрладаг бөгөөд Солонгосын тусгай хамгаалалттай газар нутгийн гуч орчим хувийг, түүний дотор 21 үндэсний цэцэрлэгт хүрээлэнг хариуцан ажилладаг. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн нь "Байгаль болон хүмүүсийн ирээдүйг холбосон тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг манлайлах" үндсэн зорилго, алсын хараатай юм. Мөн түүнчлэн үндэсний цэцэрлэгт хүрээлэнг хамгаалах, тогтвортой ашиглахад өөрийн нөөц бололцоогоо зориулж, орон

нутгийн засаг захиргаанаас удирддаг бусад тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэн ажилладаг байна[21]. Үүнд:

- Биологийн олон янз байдал, генетикийн нөөц баялаг бүхий; байгалийн экологийн бүс нутаг;
- Байгалийн үзэсгэлэнт тогтоц бүхий газар;
- Байгаль, хүрээлэн буй орчинг судлах шаардлага бүхий газар;
- Соёлын өв бүхий газар[22].

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн алба нь Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн тухай хууль, Байгалийн цогцолборт газрын тухай хуулийн дагуу байгалийн экосистем, соёлын өв бүхий газар, байгалийн нөөцийг системтэйгээр хамгаалж, удирдан зохион байгуулж, дэмжлэг үзүүлдэг. Үүнд:

- Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг арчлах, хамгаалах,
- Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн зэрлэг ан амьтдыг хамгаалах, ховордсон ан амьтдыг үржүүлэх,
- Паркийн арчилгаа, үйл ажиллагаатай холбоотой байгууламжийг суурилуулах, удирдах,
- Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, хүрээлэн буй орчинтой холбоотой судалгаа хийх,
- Байгалийн цэцэрлэгт хүрээлэнд арчилгаа цэвэрлэгээ хийх,
- Үйл ажиллагаа зохион байгуулах, удирдан чиглүүлэх, сурталчлах
- Байгаль, Аялал жуулчлалыг сурталчилан таниулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боловсрол олгох, түгээх,
- Уур амьсгалын өөрчлөлт, экологийн нөхөн сэргээлтийн улмаас байгалийн цогцолборт газруудын экологид үзүүлэх нөлөөллийн судалгаа хийх
- Байгалийн цэцэрлэгт хүрээлэнг хамгаалах, менежментийн чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг зохион байгуулах.

Зэрэг дээрх үйл ажиллагааг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн алба хариуцан ажилладаг байна.

АВСТРАЛИ УЛС

Австрали Улсад тусгай хамгаалалттай газар нутагтай холбогдон гарах харилцааг Хүрээлэн буй орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах тухай (Environment Protection and Biodiversity Conservation Act 1999)[23] хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна. Тус хууль болон түүнийг хэрэгжүүлэх журам[24] нь тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах гол эрх зүйн үндэс юм. Австрали Улс нь 1992 онд батлагдсан Биологийн олон янз байдлыг хамгаалах тухай конвенцод нэгдэн орсныхоо дагуу Австрали Улсын Үндэсний байгаль хамгаалах, хадгалах тогтолцоо (National

[21] https://www.iucn.org/our-union/members/iucn-members/korea-national-park-service

[22] https://www.knps.or.kr/portal/main/contents.do?menuNo=8000665

[23] https://www.legislation.gov.au/Details/C2023C00225

[24] https://www6.austlii.edu.au/cgi-bin/viewdb/au/legis/cth/consol_reg/epabcr2000697/

Reserve System)[25]-г үүсгэн бий болгосон байна. Энэ нь Австрали Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ бөгөөд дараах 4 төрлийн тусгай хамгаалалттай газар нутгийг багтааж байна:

- Нийтийн эзэмшлийн газар нутаг (төрийн өмчийн)
- Уугуул иргэдийн тусгай хамгаалалттай газар нутаг
- Хувийн эзэмшлийн газар нутаг
- Хамтын эзэмшлийн газар нутаг (shared management reserves).

Цаг уурын өөрчлөлт, эрчим хүч, байгаль орчин, усны яам (Department of Climate Change, Energy, the Environment and Water)-ны харьяа Байгалийн нөөцийн бодлого, хөтөлбөрийн хороо (Natural Resource Policies and Program Committee)-оос Австралийн байгалийн нөөц, баялгийг хамгаалах 2009-2030 оны стратеги (Australia's Strategy for the National Reserve System 2009-2030) [26] төлөвлөгөөг батлан, хамтын нөхөрлөл, муж улсын засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

ХУУЛИЙН БҮТЭЦ

Хүрээлэн буй орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах тухай хууль нь 5 бүлэг, 13 хэсэг, 266 зүйлтэй.

Бүлэг 1. Ерөнхий зүйл

Хэсэг 1. Ерөнхий зүйл

Бүлэг 2. Байгаль орчныг хамгаалах

Хэсэг 2. Энэ бүлгийн хялбаршуулсан тойм

Хэсэг 3. Байгаль орчны зөвшөөрөлд тавигдах шаардлага

Хэсэг 4. Байгаль орчны зөвшөөрөл шаардагдахгүй үйл ажиллагаа (зөвшөөрөл авах шаардлагагүй тохиолдлууд)

Бүлэг 3. Хоёр талт гэрээ

Хэсэг 5. Хоёр талт гэрээ

Бүлэг 4. Байгаль орчны үнэлгээ болон зөвшөөрөл

Хэсэг 6. Энэ бүлгийн хялбаршуулсан тойм

Хэсэг 7. Үйл ажиллагааны зөвшөөрөл шаардлагатай эсэхийг шийдэх

Хэсэг 8. Хяналттай үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх

Хэсэг 9. Үйл ажиллагааны зөвшөөрөл

Хэсэг 10. Стратегийн үнэлгээ

Хэсэг 11. Үйл ажиллагаанд хийгдэх үнэлгээ болон зөвшөөрлийн талаарх дүрэм

Бүлэг 5. Биологийн олон янз байдал болон соёлын дурсгалт өвийг хадгалах, хамгаалах

Хэсэг 12. Биологийн олон янз байдлыг тогтоох, хянах болон биологийн бүсчилсэн төлөвлөгөө гаргах

Хэсэг 13. Нэн ховордсон амьтад болон экологийн бүлэг

[25] https://www.dcceew.gov.au/environment/land/nrs#daff-page-main
[26] https://www.dcceew.gov.au/sites/default/files/documents/nrsstrat.pdf

Тус хуулиар амьд биетүүд (амьтан, ургамал) болон газар нутгийг үндэсний байгаль орчны ач холбогдол бүхий зүйлс гэж тодорхойлсон байна.

Эдгээрт дараах зүйлсийг хамруулна:

- Дэлхийн өвд бүртгэгдсэн газар
- Хамтын нөхөрлөлийн өвд бүртгэгдсэн газрууд
- Рамсарын конвенцод бүртгэгдсэн намгархаг газрууд
- Ховордсон амьтад болон экологийн бүлгүүдийн жагсаалтад орсон амьтад
- Олон улсын гэрээгээр хамгаалагдсан нүүдлийн төрөл зүйл амьтад
- Хамтын нөхөрлөлийн далай, тэнгисийн бүс нутгууд
- Great Barrier Reef далайн цэцэрлэгт хүрээлэн
- Цөмийн үйл ажиллагаа (ураны уурхай гэх мэт)
- Усны нөөц газрууд (нүүрсний уурхайн ашиглалттай холбоотой).

Хуулиар тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулахад Хамтын нөхөрлөлийн Байгаль орчны сайдаас зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд сайд нь уг зөвшөөрлийг олгохоос өмнө тухайн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх үр нөлөө (assessment of significant impact)-г үнэлнэ. Ингэхдээ сайд нь муж, орон нутгийн захиргааны байгууллага бүртэй хоёр талт гэрээ байгуулан тусгай хамгаалалттай газар нутагт явуулах үйл ажиллагааны үнэлгээг хамтран хийдэг байна. Хоёр талт гэрээнд заасны дагуу тухайн муж, орон нутгийн захиргааны байгууллага нь төлөвлөж буй үйл ажиллагааны тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх ерөнхий үнэлгээ буюу үйл ажиллагааны байршил, болзошгүй нөлөөллийн шинж чанар, цар хүрээ, нөлөөллийг бууруулах зарим арга хэмжээний саналыг багтаасан үнэлгээг хийж, орон нутгийн захиргааны зүгээс зөвшөөрлийг олгох эсэх саналын хамт тайланг Байгаль орчны яаманд хүргүүлнэ.[27]

Австрали Улсын засгийн газраас тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжүүлэхээр зэхсэн үйл ажиллагаанд стратегийн үнэлгээ хийдэг. Хуулийн 10-р хэсгээр стратегийн үнэлгээний талаар зохицуулалтыг хийсэн байна. Стратегийн үнэлгээ нь тухайн газар нутагт хэрэгжүүлэхээр зэхсэн үйл ажиллагааны байгаль орчин болон түүхийн дурсгалт өвд урт хугацааны явцад үзүүлэх нөлөөллийн үнэлгээ юм. Доор дурдсан талуудтай хамтран стратегийн үнэлгээг хийдэг. Үүнд:

- Австралийн засгийн газрын яам, эсхүл агентлаг
- Мужийн засгийн газар, эсхүл орон нутгийн засаг захиргааны байгууллага болон агентлаг/эрх бүхий байгууллага
- Хот байгуулалт, хөгжлийн салбар байгууллага
- Аборигенчуудын газар нутгийн зөвлөл
- Уул уурхайн болон ашигт малтмалын компани зэрэг болно.

[27] https://www.dcceew.gov.au/environment/epbc/approvals/state-assessments

Байгаль орчны сайд нь талуудтай гэрээ байгуулан стратегийн нөлөөллийн үнэлгээг хийхдээ яамны цахим хуудсанд 28 хоногийн хугацаанд тухайн үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулан саналыг авна. Үнэлгээнд үндэслэн тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлж болох эсэх шийдвэрийг гаргахдаа олон нийтийн саналыг харгалзан үзнэ. Стратегийн үнэлгээ нь тухайн тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжүүлж болох, эсхүл хориглох шаардлагатай үйл ажиллагааг өргөн цар хүрээгээр авч үздэгээрээ давуу талтай байна.

Тухайн нутаг дэвсгэрт хийгдсэн стратегийн үнэлгээ нь дараах зүйлсийг тодорхойлох замаар олон нийт, засгийн газар болон тухайн үйл ажиллагааг эрхлэхээр зэхсэн аж ахуйн нэгжүүдэд урт хугацааны баталгааг олгодог:

- Аливаа үйл ажиллагаа эрхлэх боломжгүй газар
- Үйл ажиллагаа эрхлэх боломжтой газар
- Зөвшөөрөгдөх үйл ажиллагааны төрлүүд
- Зөвшөөрлийн нөхцөл зэрэг болно.[28]

Тусгай хамгаалалттай газар нутагт ноцтой нөлөө, хохирол учруулахуйц үйл ажиллагааг хориглох бөгөөд тус хуулийн Хоёрдугаар бүлгээр зохицуулсан байна. Хэрэв ноцтой хохирол учруулсан тохиолдолд гэмт хэрэгт тооцох, хувь хүнийг 5.000 торгуулийн нэгжээр, харин байгууллагыг 50.000 торгуулийн нэгжээр торгох, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих хүртэл шийтгэл ногдуулахаар заасан байна. Тухайлбал, усны эх ундаргыг бохирдуулсан тохиолдолд 7 хүртэл жилийн ял ногдуулах, эсхүл 420 торгуулийн нэгжээр торгох, эсхүл энэ 2 шийтгэлийг хамт ногдуулахаар заажээ.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүрээлэн буй орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 12.2.2-т тусгай хамгаалалттай газар нутагт хориглох үйл ажиллагаа болон зөрчсөн тохиолдолд ногдуулах шийтгэлийг заасан байна. Үүнд дараах үйл ажиллагаа орно:

- Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ (Үүнд, археологийн болон антропологийн судалгаа, шинжилгээ орно) Гэхдээ, энэ заалт нь Аборигенчуудын газрын эрхийн тухай болон Аборигенчуудад газар олгох тухай хуульд заасан газрын зөвлөлөөс хэрэгжүүлж буй антропологийн судалгаанд үл хамаарна;
- Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд зааснаас бусад малтлага хийх болон барилга байгууламж барих;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн унаган төрх, тухайн газар нутагт байрлах байгаль, түүхийн дурсгалт зүйл, байгууламж болон тэмдэг, тэмдэглэгээ, зам харгуйг эвдэж, сүйтгэх;

[28] https://www.dcceew.gov.au/environment/epbc/approvals/strategic-assessments

- Ямар ч төрлийн (хатуу, шингэн, хийн) үйлдвэрийн хог хаягдал хаях;
- Ахуйн хог хаягдал хаях;
- Ахуйн зориулалтаас бусад нөхцөлд тусгай хамгаалалттай газар нутагт пестицид, гербицид болон бусад хортой бодис ашиглах;
- Ашигт малтмал, шавар, элс, чулууг хөндөх болон зайлуулах;
- Агуй, агуй доторх зүйлсийг эвдэж сүйтгэх болон агуй дотор урсах усанд ямар нэг бодис хийх;
- Хамтын нөхөрлөл болон муж, өөртөө засах газар нутгийн хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа эрхэлж буй хүнээс бусад хүн галт зэвсэг, ан агнуурын буу болон бусад төхөөрөмж, ашигт малтмал болон металл илрүүлэх төхөөрөмж, тэсрэх бодис, цахилгаан хөрөө, ан амьтан, загас олноор барихад зориулсан хавх, тор зэргийг ашиглах буюу эзэмших;
- Тусгай хамгаалалттай газар нутагт ан амьтан агнах, гэмтээх, зөвшөөрөлгүй нүүлгэн шилжүүлэх болон зориудаар ан амьтан нэвтрүүлэх, нутагшуулах;
- Тухайн газар нутагт ургадаг болон зөвшөөрөгдсөн ургамлаас өөр ургамал ургуулах, тариалах;
- Хориотой буюу хориглосон бүсэд нэвтрэх;
- Хориглосон газар зураг авах болон бичлэг хийх;
- Тусгай хамгаалалттай газар нутагт мөрдөх аюулгүй байдлын зааврыг дагаж мөрдөхгүй байх;
- Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас бусад эрсдэлтэй үйл ажиллагаа явуулах (өндөр уул хаданд авирах, үсрэх гэх мэт)
- Алсаас удирддаг төхөөрөмжийг нисгэх болон ажиллуулах, чанга яригч болон чанга дуу чимээ гаргадаг аливаа төхөөрөмж ашиглах, тухайн тусгай хамгаалалттай газрын удирдлагаас зөвшөөрөөгүй газар зөөврийн цахилгаан үүсгүүр ашиглах;
- Тухайн газар нутгийн удирдлагаас зөвшөөрсөн амарч буудаллах хэсгээс бусад хэсэгт буудаллах, газрын гадаргууг ухах, мод бутыг хугалах, зөөврийн цахилгаан үүсгүүр зэрэг хэрэгслүүдийг ашиглах;
- Тухайн газар нутгийн удирдлагаас зөвшөөрсөн гэр бүлийн уулзалт зэрэг зохион байгуулалттай арга хэмжээнээс бусад 15-аас дээш хүний цугларалтад оролцох;
- Зөвшөөрөгдсөн газраас бусад газар хүн оршуулах;
- Түр эсхүл байнга орших дурсгалын зүйл бүтээх;
- Хамтын нөхөрлөл, муж болон өөртөө засах газар нутгийн хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд арилжааны зорилгоор загас агнуур хийх;
- Хориотой газар түүнчлэн тодорхой хугацаанд загасчлахыг хориглосон газар загасчлах болон зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү тоо хэмжээгээр загасчлах;
- Зөвшөөрөгдсөнөөс бусад арилжааны зорилготой үйл ажиллагаа эрхлэх;
- Какаду Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд согтууруулах ундаа зарж борлуулах;

- Тусгай хамгаалалттай газар нутагт авсан гэрэл зургуудыг арилжааны зорилгоор ашиглах;
- Тодорхой зөвшөөрөлгүй газар туг, далбаа, арилжааны самбар байршуулах зэрэг болно.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ЗӨВШӨӨРӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хуульд зааснаар тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөтэй нийцэж байгаа болон тухайн газар нутгийн удирдах газраас олгосон зөвшөөрлийн дагуу аялал жуулчлал, арилжааны зорилготой кино зураг авалт болон гэрэл зураг авах, судалгаа, шинжилгээ хийх, түүнчлэн аливаа тэмдэглэлт арга хэмжээ зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа багтаж байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөгдөх үйл ажиллагаанаас аялал жуулчлалын үйл ажиллагаа чухал ач холбогдолтойд тооцогддог бөгөөд Австрали Улсын эдийн засагт тодорхой хувь нэмрийг оруулдаг байна. 2021-2022 оны байдлаар аялал жуулчлалын салбар нь ДНБ-ийн 1.6%-ийг бүрдүүлсэн байна. 2022 оны Зургадугаар сарын байдлаар 358.300 аж ахуйн нэгж аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байна. 2023 оны Зургадугаар сарын байдлаар тус салбарт 713.000 хүн ажил эрхэлж байна. Тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжүүлж буй аялал жуулчлал, амралт сувиллын үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангахын сацуу нийгмийн томоохон асуудал болох иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зэрэг чухал ач холбогдолтой байна.

ФИЛИППИН УЛС

Филиппин Улс нь 7.8 сая га бүхий 247 тусгай хамгаалалттай газар нутагтай. Тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах зорилгоор шинээр тусгай хамгаалалттай газруудыг байгуулах, эрх зүйн орчныг сайжруулах, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцоог бий болгох зэрэг арга хэмжээг авч иржээ.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1992 онд Тусгай хамгаалалттай газар нутгийг нэгдсэн системд бүртгэлжүүлэх ажлыг эхлүүлж, энэ зорилгоор *Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны тухай хуулийг*[29] (7586 дугаар хууль) батлан, тусгай хамгаалалттай газар нутгийг удирдах, зохион байгуулах харилцааг хуульчилжээ. Улмаар 2018 онд дээрх хуулийг өргөтгөн нэмэлт, өөрчлөлт оруулж *Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны өргөтгөсөн хууль*[30] (11038 дугаар хууль)-ийг баталсан байна.

- *Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны тухай хууль* (Бүгд Найрамдах Улсын № 7586 дугаар хууль, 1992 он),

[29] https://chanrobles.com/RA7586.htm
[30] https://lawphil.net/statutes/repacts/ra2018/ra_11038_2018.html

Republic Act No 7586 or the National Integrated Protected Areas System Act of 1992 (NIPAS);

- *Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны өргөтгөсөн хууль* (Бүгд Найрамдах Улсын 11038 дугаар хууль, 2018 он), Republic Act No 11038 or the Expanded National Integrated Protected Areas System (E-NIPAS) Act of 2018.

Дээрх хуулиудад тусгай хамгаалалттай газар нутгийг "*физик, биологийн онцгой ач холбогдлоор нь тусгаарласан, биологийн олон янз байдлыг сайжруулсан, хүний хор хөнөөлтэй үйл ажиллагаанаас хамгаалагдсан газар, усны тодорхой хэсгийг хэлнэ*[31] хэмээн тодорхойлжээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцоо (NIPAS)-д хуурай газар болон усны эрэг, эсхүл тэнгисийн экологийн хувьд баялаг бөгөөд өвөрмөц газар нутгууд ба ургамал амьтны төрөл зүйл нь ховор бөгөөд устах эрсдэлтэй, биологийн хувьд чухал олон нийтийн газрууд, био-газарзүйн бүсүүд ба холбогдох экосистемүүд гэхчлэн "хамгаалалттай газар" гэж нэрлэх шаардлагатай бүх газрууд хамаардаг байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны тухай хуулийн 3 дугаар хэсэгт дараах ангиллаар тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулна гэж заасан байдаг:[32]

a. Байгалийн нөөц, хатуу хамгаалалттай газар;
b. Байгалийн цэцэрлэгт хүрээлэн парк;
c. Байгалийн дурсгалт газар;
d. Зэрлэг ан амьтдын дархан цаазат газар;
e. Хамгаалалттай газар нутаг болон тэнгисийн бүс;
f. Байгалийн баялгийн дархан цаазат газар;
g. Байгалийн олон янз байдлын бүс;
h. Филиппиний Засгийн газрын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, хуулиар тогтоосон бусад ангиллууд.

Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны өргөтгөсөн хуулиар байгалийн болон соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, хөгжүүлэлт, биологийн чухал ач холбогдолтой газар нутгуудыг уугуул төрх байдлаар хадгалан хамгаалах, нөхөн сэргээх, зөвшөөрсөн болон хориглосн үйл ажиллагаа, авах арга хэмжээ, тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагааг хариуцсан байгууллагын чиг үүрэг зэрэг харилцааг хуульчилсан.

Тус хуульд зааснаар тусгай хамгаалалттай газар нутгийг (дархан цаазат газар нутгаас бусад) эвдэж, гэмтээхээргүй байх нөхцөлд эрчим хүчний нөөц баялгийн

[31] https://chanrobles.com/RA7586.htm
[32] https://www.informea.org/en/content/legislation/denr-administrative-order-no-2019-05-implementing-rules-and-regulations

хайгуулыг зөвхөн мэдээлэл, өгөгдөл цуглуулах зорилгоор хийж болно. Сэргээгдэх эрчим хүчний төслийг гагцхүү Байгаль орчин, байгалийн нөөцийн газар (DENR)-ын нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр явуулж болдог байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сан (IPAF)-г тусгай хамгаалалттай газар нутгуудийн болон тогтолцооны төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор байгуулна. Тусгай хамгаалалттай газар нутгийн санд олгож буй бүх санхүүжилт, хандивыг татвараас чөлөөлнө. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь хууль, дүрэм, журмын зөрчлийг Хууль зүйн газраас мөрдөн шалгадаг. Тусгай хамгаалалттай газар нутаг болон түүний хамгаалалттай бүсүүд дэх урьд өмнө оршиж байсан бөгөөд энэ хуулиар хүчин төгөлдөр олгогдсон бүх эд хөрөнгө, хувийн эрхийг хамгаалж, хүндэтгэнэ. Мөн энэ хуулийн хэрэгжилтийн хяналтыг Конгрессийн хамтарсан хяналтын хороо тавьдаг байна.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙГ ХАРИУЦСАН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцоо нь Байгаль орчин, байгалийн нөөцийн газрын хяналтад байдаг байна.

Байгаль орчин, байгалийн нөөцийн газар нь (Department of Environment and Natural Resources)[33] нь улс орны байгаль орчин, байгалийн баялаг, тухайлбал: ой, бэлчээрийн газар, ашигт малтмал, тэр дундаа дархан цаазат газар, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, нийтийн эзэмшлийн газрыг хамгаалах, удирдах, хөгжүүлэх, зүй зохистой ашиглах, түүнчлэн тусгай зөвшөөрөл, Филиппиний одоо болон хойч ирээдүй үеийнхний сайн сайхны төлөө олсон үр шимийг тэгш хүртэх зорилгоор хуулиар тогтоосон байгалийн бүх нөөцийг зохицуулах асуудал эрхэлсэн үндсэн байгууллага юм.

Байгаль орчин, байгалийн нөөцийн газар (нарийн бичгийн дарга) нь дараах эрх мэдлийг хэрэгжүүлнэ:

a. Тусгай хамгаалалттай газруудын онцлог болон нийтлэг шинж чанаруудыг судалж, ангилах ба хүний үйл ажиллагаанд зөвшөөрөх болон хориглох үйл ажиллагааг нийт тогтолцоон дахь категори тус бүрээр ангилан тодорхойлно;
b. Газар ашиглалтын схем, тусгай хамгаалалтын газар нутгийн бүсийг тогтоох төлөвлөгөө, хамгаалалттай газар нутгийн экологийн тэнцвэрийг алдагдуулж болзошгүй үйл ажиллагааг хянан сэргийлэх зэрэг ажлыг төлөвлөн боловсруулж, хэрэгжүүлэх;
c. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн талаарх бүх санал санаачилга, төлөвлөгөөг боловсруулан бэлтгүүлэх, хянах;
d. Холбогдох хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журмуудыг баталж мөрдүүлэх;
e. Засгийн газрын агентлагууд болон аливаа хувь хүн, тусгай хамгаалалттай газар нутгаас ашиг шим хүртэж буй аливаа аж ахуйн нэгж, корпорациас

33 https://www.denr.gov.ph/

хурааж авах Үндэсний нэгдсэн тусгай хамгаалалттай газар нутгийн тогтолцооны төлбөр хураамжийг үндэслэл сайтай тогтоон тодорхойлох;

f. Тусгай хамгаалалттай газар нутгийн хадгалалт, хамгаалалтыг эрсдэлд оруулж, зөрчсөн тохиолдолд ногдуулах захиргааны төлбөр, торгуулийн хэмжээг тогтоон шийдвэрлэх;
g. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны өргөтгөсөн хуульд заасан албан үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хувийн аж ахуйн нэгж болон олон нийтийн агентлагуудтай гэрээ, хэлэлцээр байгуулах;
h. Филиппиний Засгийн газрын нэрийн өмнөөс болон Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны сангийн нэрийн өмнөөс бэлэг, шууд хэлбэрийн мөнгөн төлбөр, мөнхүү тогтолцооны ашиг сонирхол, үйл ажиллагаа, ажил үйлчилгээний төлөө бусад хөрөнгийг хүлээн авах;
i. Тогтолцооны зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзвэл Засгийн газрын аливаа агентлаг болон арга хэрэгсэл, тэрчлэн эрдэм шинжилгээний байгууллага, хувийн салбарыг татан оролцуулах;
j. Улс орны тусгай хамгаалалттай газар нутгуудын статусын талаар Филиппин Улсын Ерөнхийлөгч болон Конгресст жил тутамд тайлагнах;
k. Тогтолцоонд хамаарах ангилал тус бүрээр нийт тогтолцооны нийтлэг нэг тэмдэглэгээг Засгийн газрын холбогдох агентлагууд, олон нийтийн болон хувийн байгууллагуудтай зөвшилцсөнөөр бий болгох;
l. Тусгай хамгаалалттай газар нутагт барих барилга болон бусад байгууламжуудын ангилал, төрөл зүйл, загварыг болон хэрэглэх материалыг заан тодорхойлох;
m. Тусгай хамгаалалттай газар нутгийн хүрээн дэх барилга байгууламж, зам, усны хангамж, усны шугам сүлжээ, галын аюулгүй байдал, ариутгах төхөөрөмж, бусад нийтийн хэрэглээний байгууламжуудын үйл ажиллагаа, ашиглалтыг хянах;
n. Тусгай хамгаалалттай газар нутагт зохистой хувь хэмжээгээр иргэдийг суурьшуулах, тус нутаг дахь ойн уугуул иргэдээс бусад оршин суугчдыг гадагш нүүлгэн шилжүүлэх зэрэг ажлыг хянах;
o. Филиппиний Ерөнхийлөгчөөс үүрэг болгосон, тэрчлэн тогтолцооны зорилго зорилтыг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай ажил үүргүүдийг гүйцэтгэх.

Мөн Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн зөвлөл буюу удирдах зөвлөлийг (цаашид Удирдах зөвлөл гэх)[34] байгуулан ажиллана. Тус Удирдах зөвлөл нь бүс нутгийн Байгаль орчин, байгалийн нөөцийн салбар нэгжүүдийн дарга; муж, орон нутгийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжлийн төлөөлөл, уугуул иргэдийн төлөөлөл, их дээд сургууль, холбогдох судалгааны байгууллагын төлөөлөл зэрэг 10 гаруй гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна. Гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож, Байгаль орчин,

[34] https://lawphil.net/statutes/repacts/ra2018/ra_11038_2018.html

байгалийн нөөцийн газрын дарга 3 жилийн хугацаатай томилно. Удирдах зөвлөл нь:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд хяналт тавих;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг баталж, түүний хэрэгжилтийг хангах;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр нөлөөг үнэлэх;
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах, нягтлан бодох бүртгэл, төсөв тооцоог холбогдох дүрэм, журмын дагуу удирдан зохион байгуулах;
- Холбогдох төлбөр, хураамжийн хэмжээг тогтоох зэрэг үйл ажиллагааг явуулна.

Байгаль орчин, байгалийн нөөцийн газар, түүний салбар нэгжүүд, Удирдах зөвлөл зэрэг байгууллагууд нь тусгай хамгаалалттай газар нутгуудын удирдлага зохион байгуулалтыг хариуцаж, аль болохоор тэдгээрийг байгалийн унаган төрхөөр нь хадгалах, хамгаалахыг сурталчлан ажилладаг. Үүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь **үндэсний болон орон нутгийн засгийн газрууд, холбогдох хувийн байгууллагуудын хоорондох хамтын ажиллагааны дүнд бий болдог байна.**

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ЗӨВШӨӨРСӨН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн дархан цаазат газарт хориглосон үйл ажиллагаанаас бусад тохиолдолд тусгай зориулалтын ашиглалтыг зөвшөөрдөг байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдах зөвлөлөөс судалгаа, үнэлгээ хийсний үр дүнд байгаль орчны үнэлгээний шаардлагад нийцсэн төсөлд байгаль орчны нийцлийн зөвшөөрөл олгоно. Тухайн үйл ажиллагаа нь экосистемийн үйл ажиллагаа, биологийн олон янз байдал, соёлын зан үйл, уламжлалд хор хөнөөл учруулахгүй байх ёстой.

Төсөл хэрэгжиж буй хамгийн ойрын нутаг дэвсгэр буюу хотын захиргаанд байрлах аж ахуйн нэгжийн газрын бүсчилсэн үнэлгээний таван хувь (5%)-тай тэнцэхүйц ашиглалтын зохих төлбөрийг бүтээн байгуулалтын талбайгаар үржүүлж төлнө. Төлбөрийн хэмжээ, тавигдах шаардлагыг Удирдах зөвлөл болон Байгаль орчин, байгалийн нөөцийн газраас тогтооно.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ХОРИГЛОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА[35]

Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны тухай өргөтгөсөн хуулийн **20 дугаар зүйлд Тусгай хамгаалалттай газар нутагт хориглох үйл ажиллагааг дараах байдлаар зохицуулжээ: Тухайлбал,**

[35] https://lawphil.net/statutes/repacts/ra2018/ra_11038_2018.html

(a) Тусгай хамгаалалттай газар нутагт (энэ нутагт хамаарах хувийн өмчийн газруудыг мөн оролцуулна) аливаа зэрлэг ан амьтныг хулгайгаар агнах, алах, устгах, үргээх;

(b) Албан ёсны зөвшөөрөл, эсхүл тушаал шийдвэр, тусгай нөхцөлгүйгээр тусгай хамгаалалттай газар нутагт (энэ нутагт хамаарах хувийн өмчийн газрыг мөн оролцуулна) аливаа зэрлэг ан амьтныг, эсхүл тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүнийг агнах, авах, түүж цуглуулах, эзэмших: (Холбогдох эрх бүхий газрын зөвшөөрлөөр сургийн бүтцийг сайжруулах зорилгоор өвчтэй, амьдрах чадваргүйг нь устгах, судалгаа шинжилгээний ажил хийх, олон талт ашиглалтын бүсүүд дэх тусгай хамгаалалтад ороогүй төрөл зүйлийг хураан авах зэрэгт зөвшөөрөл, тусгай нөхцөлийг олгоно);

(c) Ховор төрөл зүйлийг хамгаалах зорилгоор цэвэрлэгээ хийхээс бусад тохиолдолд албан ёсны зөвшөөрөл, тушаал, гэрчилгээгүйгээр тусгай хамгаалалттай газар нутагт, мод бут огтлох, хурааж цуглуулах, байрнаас нь хөдөлгөх;

(d) Онцгой ховор төрөл зүйлээс бусдыг албан ёсны зөвшөөрөлтэйгөөр гаргах, эсхүл цэвэрлэгээ хийхээс бусад тохиолдолд аливаа мод бут, ойн бүтээгдэхүүн, ан амьтан, эсхүл тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүнийг эзэмших, эсхүл тусгай хамгаалалттай газар нутгаас гаргах;

(e) Байгаль орчин, байгалийн нөөцийн газрын тодорхойлсон шүрэн хад, тэнгисийн ёроолын ургамал, эсхүл уугуул оршин суугчид болон оршин суугчдын амьдралтай холбоотой, тэнгисийн амьдралыг устгах эрсдэлтэй аливаа загас агнуур болон хадлангийн багаж төхөөрөмж, тэдгээрийн төрөл зүйлийг хэрэглэх, үйл ажиллагаа явуулах;

(f) “1990 оны Хорт бодис, аюултай болон цөмийн хог хаягдлын тухай хууль”-д тусгай хамгаалалттай газар нутагт болон түүний ургамал амьтан, оршин суугчдад хор хөнөөлтөй гэж тодорхойлсон аливаа хорт химийн бодис, хор хөнөөлтэй эд зүйл, байгальд задардаггүй материал, боловсруулаагүй хог хаягдал, амьтны ялгадас эсхүл бүтээгдэхүүн зэргийг тусгай хамгаалалттай газар нутагт шингэн, хатуу, хийн аливаа төлөв байдалтайгаар ил задгай хэрэглэх, хаях, булах, эсхүл хаях нөхцөл шалтгааныг бүрдүүлэх, хадгалан байршуулах;

(g) Соёлын болон байгалийн аливаа өв, баялгийг уугуул газар руу нь моторт тээврийн хэрэгслээр зөөн байрлуулахаас бусад тохиолдолд Удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр аливаа моторт тээврийн хэрэгсэл ажиллуулах;

(h) Хил хязгаарын тэмдэг, тэмдэглэгээг өөрчлөх, авч хаях, устгах, гэмтээх;

(i) Тусгай хамгаалалттай бүс дотор ойн түймэр дэгдэх шалтгаан бий болгох;

(g) Байгалийн тогтоц, шашин номын болон түүхэн дурсгалт газрууд, онгон шүтээний өвөрмөц төрх байдал, үнэ цэнэ бүхий эд зүйлсийг сэвтээх, гэмтээх, эвдэж устгах, ухаж сэндийчих, талхлан сүйтгэх хэлбэрээр гэмтээх;

(k) Зам, гарцыг гэмтээх, газар сэвтээсэн байдалтайгаар зам гарцгүй газраар зорчих;

(l) Шүлс, ялгадсаа газарт болон усанд ил задгай хаях, бохирдуулах;

"(m) Хамгаалалттай газрын хаа нэгтээ тэсэрч дэлбэрэх бодис хадгалан авч явах, эсхүл хэрэглэх;

"(n) Тусгай хамгааллалттай бүсийн нийтийн эзэмшлийн газарт Удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр буух, орогнох;

"(o) Удирдах зөвлөл болон Байгаль орчин, байгалийн нөөцийн газрын зөвшөөрөл хяналтгүйгээр аливаа хашаа, байшин, байгууламж барьж байгуулах, холбогдох газраас батлагдсан менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцэхгүй бизнесийн үйл ажиллагаа эрхлэх;

(p) Хамгаалалттай газар нутгаас эрдэс баялгийн хайгуул, олдворлолт хийх;

(q) Тусгай хамгаалалттай газар нутагт худалдаа арилжаа, эсхүл өргөн цар хүрээтэй малтлага зэргийг хийх;

(r) Тусгай хамгаалалттай газар нутагт GMOs болон өөр ховор төрөл зүйлийг бий болгох, нэвтрүүлэх;

(s) Удирдах зөвлөлийн журмын дагуу урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр тусгай хамгаалалттай газар нутгаас эмийн болон бусад зориулалтын ургамал түүх, судлах, цуглуулах: (энэ хуульд заасан шийтгэлүүдээс гадна Тусгай хамгаалалттай газар нутгаас зөвшөөрөлгүйгээр аливаа зүйлийг арилжаа худалдааны зорилгоор түүх, авах, хэрэглэхийг зөвшөөрөхгүй бөгөөд энэ мэт хууль бус арилжаагаар олсон бүх ашгийг нь хураан авч Тусгай хамгаалалттай газар нутгийн санд шилжүүлнэ);

(t) Тусгай хамгаалалттай газар нутагт ямар нэгэн нууц эрдэнэсийг хайх, ухах, байршлыг нь судлан тогтоох;

(u) Тусгай хамгаалалттай газар нутаг дахь аливаа газар, хэсгийг худалдан авах, зарж борлуулах, зээлийн барьцаанд тавих, түрээслэх;

'(v) Аливаа байгалийн усны эх, ундаргаас 40 метрийн зайнд ямар нэгэн байгын барилга байгууламж барих, эсхүл барих зөвшөөрөл олгох (Гагцхүү Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдах зөвлөлийн зөвшөөрлөөр нийтийн усны нөөц болон эргийн хамгаалалтын зорилгоор байгууламж барихыг зөвшөөрнө)-ыг тус тус хориглоно.

Тусгай хамгаалалттай газар нутгуудад хууль, журам зөрчигчдийг шийдвэрлэх тусгай прокуроруудыг Хууль зүйн газраас томилдог бөгөөд тэдгээр нь тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, зөрчлийг шалган илрүүлэх ажлыг зохион байгуулдаг. Хохирлын үнэлгээг хийхдээ биологийн олон янз байдал, байгаль хамгаалал, гоо зүйн болон байгалийн үзэмжийн үнэ цэнийг харгалзан үзнэ. Нотлох баримтын давамгайллаар өөрөөр нотлогдоогүй бол Байгаль орчин,

байгалийн нөөцийн газар нь бусад холбогдох төрийн байгууллагуудтай хамтран үнэлгээг хянан шалгана.

Хуульд (11038 дугаар) зааснаар Тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулах, хууль зөрчсөн үйлдэл гаргасан тохиолдолд дараах шийтгэлийг ногдуулна. Тухайлбал,

- Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны тухай хууль болон холбогдох аливаа дүрэм, журмыг зөрчсөн, эсхүл хуулийн аль нэг заалтыг зөрчсөн нь хууль, шүүхээр тогтоогдсон тохиолдолд тухайн этгээдийг хоёр зуун мянган песогоос (P200,000) багагүй, нэг сая песогоос (P1,000,000) ихгүй хэмжээгээр торгох, эсхүл 1-6 жилээс хүртэлх хугацаагаар хорих, эсхүл хоёуланг нь ногдуулж болно. Мөн эдгээр шийтгэл дээр нэмээд эвдэж гэмтээсэн зүйлийн үнийг 3 дахин нэмэгдүүлж төлнө;
- 11038 дугаар хуулийн 20 дугаар хэсгийн (o-v) хүртэл зүйлд хамаарах үйл ажиллагааг зөрчсөн тохиолдолд 1 саяаас (P1,000,000) 5 сая (P5,000,000) хүртэл песогоор торгох, эсхүл 6-12 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна.
- Хамгаалалттай газар нутгийн доторх тоног төхөөрөмж (барилга байгууламж, усан сангийн төхөөрөмж) техник хэрэгсэл нь байгаль орчинд аюул учруулахуйц нөхцөл байдалтай байгаа нь Байгаль орчны хяналтын байгууллагын үнэлгээгээр тогтоогдвол залруулах тухай шаардлага тавьж, өдөр тутамд нь 50 мянган песоны торгууль ногдуулна. Торгуулийн хэмжээ нь 500 мянган песо хүрвэл эзэмшигчийнх нь өөрийнх нь зардлаар тухайн төхөөрөмжийг устгуулна.
- Хэрэв тухайн газар нутгийг нөхөн сэргээх, эсхүл сэргээн засах шаардлагатай гэж шүүхээс шийдвэрлэвэл тэрхүү эвдрэл гэмтлийг сэргээн засварлах, эсхүл нөхөн сэргээх ажлын өртгийг гэм буруутай этгээд хариуцна.
- Мөн шүүхээс гэм буруутай этгээдийг тухайн хамгаалалттай газраас хөөж гаргах, хөндөж авсан бүх эрдэс баялаг, мод, эсхүл аливаа зүйлийг, улмаар хэрэглэсэн бүх багаж төхөөрөмж, машин техник, галт зэвсэг, гэмт этгээдийн барьж байгуулсан аливаа барилга байгууламж, эсхүл засвар хийсэн эд зүйлс зэргийг Улсын мэдэлд хураан авах шийдвэрийг гаргана.
- Хэрвээ гэм буруутай этгээд нь ямар нэг байгууллага, эсхүл корпорац бол түүний ерөнхийлөгч, эсхүл менежер нь ажилтан, албан хаагчдынхаа үйлдэлд шууд хариуцлага хүлээнэ.
- Байгаль орчин, байгалийн нөөцийн газар нь Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний нэгдсэн тогтолцооны өргөтгөсөн хуульд нийцүүлэн захиргааны торгууль, шийтгэлийг ногдуулж болно.

ОХУ-ЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

ОХУ-ын нийт газар нутгийн хэмжээ**: 17.075.400 км² .** Үүний **2,7** хувийг Тусгай хамгаалалттай газар нутаг эзэлж байна. ОХУ-д Байгалийн тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, хууль, эрх зүйн хариуцлага тооцох, стандартыг мөрдүүлэх, тусгай хамгаалалтын газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг Засгийн газар нь хариуцдаг.[36] ОХУ-ын Байгалийн нөөц экологийн яам нь, Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, хууль дүрмийг мөрдүүлэх, судалгаа хийх зэрэг төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.

Хил орчмын тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, ховордсон ан амьтныг нутагшуулах, Байгалийн эко системийг хадгалж хамгаалахад Монгол Улсын болон БНХАУ-ын Засгийн газартай хамтран ажиллаж ирсэн байна.[37]

Тусгай хамгаалалттай байгалийн газар гэдэг нь байгаль орчин, шинжлэх ухаан, соёл урлаг, гоо зүй, амралт, эрүүл мэндийн онцгой ач холбогдолтой байгалийн цогцолбор, газар, усны гадарга, тэдгээрийн дээгүүр агаарын орон зайг бүхэлд нь төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хамгаалсан газар нутаг юм.

ОХУ-ын Тусгай хамгаалалттай Байгалийн газрын тухай холбооны хуульд[38], “Тусгай хамгаалалттай байгалийн газар гэж **байгаль орчин, шинжлэх ухаан, соёл урлаг, гоо зүй, амралт зугаалга, эрүүл мэндийн онцгой ач холбогдолтой байгалийн цогцолбор, объект, ургамал, байгаль экологийн тогтолцоотой газар, усны гадаргуу, агаарын орон зайн бүс нутаг юм” гэж тодорхойлжээ.**

Тусгай хамгаалалттай байгалийн газар нутгийг **үндэсний өвийн объект** гэж ангилдаг.

Энэхүү Холбооны хууль нь, байгалийн өвөрмөц, өвөрмөц цогцолбор, объект, ургамал, амьтан, байгалийн экологийн систем, биологийн олон янз байдлыг хадгалах, шинжлэх ухааны судалгаа хийх зорилгоор тусгай хамгаалалттай байгалийн газар нутгийг бий болгох, түүний дотор хамгаалах, ашиглах харилцааг зохицуулдаг.

ОХУ-д Тусгай хамгаалалттай байгалийн газар нутгийг үндэсний өвийн объект гэж үздэг.

Тусгай хамгаалалттай газар нутгийн төрөл:

Тусгай хамгаалалттай байгалийн нутаг дэвсгэрийн дэглэмийн онцлогийг харгалзан дараах байдлаар ангилна:

a) улсын байгалийн нөөц газар, үүнд биосферийн нөөц газар орно;

b) үндэсний цэцэрлэгт хүрээлэнгүүд;

c) байгалийн цэцэрлэгт хүрээлэн;

---

[36] http://www.mnr.gov.ru/

[37] http://government.ru/department/48/events/

[38] https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_6072/

г) улсын байгалийн нөөц газар;
е) байгалийн дурсгалт газрууд;
ё) цэцэрлэгт хүрээлэн, ботаникийн цэцэрлэг;
ж) Шим мандлын нөөц..

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

1. Тусгай хамгаалалттай байгалийн бүс байгуулах шийдвэр гаргахдаа дараах зүйлийг харгалзан үзнэ.

а) ургамал, амьтны ховордсон, эдийн засаг, шинжлэх ухааны хувьд үнэ цэн бүхий, тэдгээрийн амьдрах орчныг багтаасан биологийн олон янз байдлыг хамгаалах ач холбогдол;

б) тухайн нутаг дэвсгэрийн хилийн доторх, шинжлэх ухаан, соёлын онцгой ач холбогдолтой байгалийн ландшафт, соёлын өв бүс нутаг;

в) холбогдох нутаг дэвсгэрийн хилийн дотор шинжлэх ухаан, соёл, гоо зүйн онцгой үнэ цэнтэй геологи, минералоги, палеонтологийн дурсгалт газрууд;

2. Тусгай хамгаалалттай байгалийн бүс нутаг дахь суурин газарт хот төлөвлөлтийн харилцааг зохицуулах

- Улсын нөөц газраас бусад тохиолдолд байгалийн олон янз байдлыг нь алдагдуулахгүй үйл ажиллагаа явуулах;
- Хот төлөвлөлтийн журамд тохирох шаардлагыг хангах ;

Тусгай хамгаалалттай байгалийн газар нутгийн улсын кадастр:

- Газарзүйн байршил, хил хязгаар, шинжлэх ухаан, эдийн засаг, түүх, соёлын үнэт зүйлсийн талаарх мэдээллийг багтаана.
- Тусгай хамгаалалттай байгалийн газар нутгийн улсын кадастрын бүртгэлийг байгалийн нөөцийн сангийн төлөв байдлыг үнэлэх, нутаг дэвсгэрийн сүлжээг хөгжүүлэх, хэтийн төлөвийг тодорхойлох, хамгаалах чиглэлээр төрийн хяналтыг сайжруулах зорилгоор хөтөлдөг.

ОХУ-ЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ЗӨВШӨӨРСӨН ҮЙЛ АЖИЛЛАГАА;

- Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн эко систем, янз байдлыг алдагдуулахгүйгээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн эзэмшил, ашиглалтыг хөндөхгүйгээр хамгаалах

- Тусгай хамгаалалттай газар нутгийг аялал жуулчлал, судалгаа, боловсролын чиглэлээр ашиглах

- Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг тэлэх хэрээр хариуцлагагүй уул уурхай, баялгийн тэгш бус хуваарилалт, байгалийн өвийг сүйтгэх сөрөг үр дагавраас хамгаалахь тодорхой байгалийн дурсгалт газрыг унаган төрхөөр нь хадгалж үлдэх, байгалийн биет болох биет бус өв, баялгийг үр хойчдоо өвлүүлэн үлдээхэд чиглэсэн байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, менежментийг сайжруулахад газар нутгийг, экосистемийг уламжлалт аж ахуй, соёл, байгалийн нөөц ашиглалтын менежменттэй уялдуулдаг байна.[39] Мөн төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх түүчлэн нутгийн иргэдийн оролцоог дэмжиж ажилладаг байна.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ХОРИГЛОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Тусгай хамгаалалттай газар нутагт ашигт малтмалын хайгуул олборлолт хийх
- Байгалийн тэнцвэрт сөрөг нөлөөлөл үзүүлэх аливаа үйл ажиллагаа явуулах
- Байгалийн янз байдалд нөлөөлөхүйц барилга дэд бүтцийг бий болгох гэх мэт хуулиар хориглосон аливаа үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд хуулиар хариуцлага хүлээлгэх нарийн зохицуулалттай

БНХАУ

БНХАУ-д нийт 11800 гаруй тусгай хамгаалалттай газар байх бөгөөд энэ нь БНХАУ-ын нийт газар нутгийн 18%-ийг эзэлдэг байна. Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн нөөц газар, ойн бүс газар, байгалийн үзэмжит газар, үндэсний цэцэрлэгт хүрээлэн, цэвэр усны нөөцийн тусгай хамгаалалттай газар, далайн эргийн тусгай хамгаалалттай газар зэрэг хамаардаг байна[40]. БНХАУ-ын тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах үндсэн зорилго нь байгалийн унаган төрх байдал, эко систем болон биологийн олон төрөл зүйлийн ургамал, зэрлэг амьтад зэргийг хамгаалахаас гадна тухайн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих явдал юм. БНХАУ-д 300 гаруй зэрлэг амьтан, 130 гаруй зэрлэг ургамал тусгай хамгаалалтад байдаг байна.

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

БНХАУ-ын тусгай хамгаалалттай газар нутагт хамаарах хууль нь БНХАУ-ын Үндсэн хууль, БНХАУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БНХАУ-ын Байгалийн нөөц газрын тухай журам болон бусад холбогдох хуулиуд байна.

БНХАУ-ын Үндсэн хуульд БНХАУ-ын байгалийн баялгийг хамгаалах, өмчлөх тухай ерөнхийд нь заасан байдаг байна.

[39] https://top-technologies.ru/ru/article/view?id=33192
[40] https://www.mdpi.com/2071-1050/12/15/5879#B14-sustainability-12-05879

БНХАУ-ын Үндсэн хуулийн 9-р зүйлд “Ашигт малтмал, ус, ой, уул, бэлчээрийн тал, онгон байгаль, далайн эрэг мөн байгалийн бусад баялаг нь төрийн өмчлөлд буюу бүх ард түмний өмч юм. Төр байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах болон ховордсон амьтан ургамлыг хамгаалах үүрэгтэй бөгөөд аливаа албан байгууллага, хувь хүн байгалийн баялагт халдах болон зүй зүй зохисгүй ашиглахыг хориглоно.[41]” гэж заасан байна.

БНХАУ-ын Үндсэн хуулийн 22-р зүйлд “Төр нь байгалийн үзэсгэлэнт газар болон түүхийн дурсгалт газар, соёлын өв болсон газар, мөн бусад чухал өв газруудыг хамгаална” гэж заасан байна.

БНХАУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн[42] 17-р зүйлд байгаль орчныг хамгаалах засгийн газрын үүргийг заасан байдаг байна.

Тус хуулийн 18-р зүйлд “Төрийн Зөвлөл, Төрийн Зөвлөлийн дэргэдэх холбогдох эрх бүхий байгууллага, орон нутгийн удирдлага, өөртөө засах орон зэргээс тогтоосон байгалийн үзэсгэлэнт газар, түүхэн дурсгалт газар, байгалийн нөөц газар болон бусад тусгай хамгаалалтад авах шаардлагатай бүс нутагт байгаль орчныг бохирдуулах үйлдвэрлэлийн байгууламж барихгүй байх, мөн эдгээр газарт баригдах бусад байгууламжуудын бохирдлын хэмжээ тогтоосон стандартаас хэтрэхгүй байх ёстой. Хэрэв тус барилга байгууламжаас бохирдлын хэмжээ тогтоосон стандартад заасан хэмжээнээс их хэмжээгээр ялгаруулж байгаа бол тогтоосон хугацаанд уг бохирдлыг арилгах буюу хяналтад авна” гэж заасан байна.

БНХАУ-ын Байгалийн нөөц газрын тухай журам нь БНХАУ-ын тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах хамгийн чухал журам юм. Тус журам нь тусгай хамгаалалттай газрын байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалахад чиглэдэг байна. Мөн уг журамд “Тухайлсан газар нутгийг дархан цаазат газар болгож тусгай хамгаалалтад авах тохиолдолд тухайн орон нутгийн эдийн засгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл болон үйлчилгээний үйл ажиллагаа түүнд холбогдох барилга байгууламж, иргэдийн ахуй амьдралыг харгалзан үзэх ёстой” гэж заасан байна. Тус журмын 21-р зүйлд “Тусгай хамгаалалттай газар нутгийг тухайн аймаг болон өөртөө засах орны засаг захиргааны харьяа тусгай хамгаалалттай газар хариуцсан хэлтэс эвэл Төрийн зөвлөлийн харьяа тусгай хамгаалалттай газар хариуцсан хэлтэс хариуцна” гэж заасан байна. Мөн журмын 26, 27-р зүйлд тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа, 32, 33-р зүйлд тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэх ерөнхий арга хэмжээг тайлбарласан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай дараах хуулиудад мөн адил холбогдох зүйл заалтууд тусгагдсан байна[43]. Үүнд: БНХАУ-ын Зэрлэг амьтдыг хамгаалах тухай хууль, Зэрлэг ургамлыг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль,

[41] https://www.mdpi.com/2071-1050/12/15/5879#B14-sustainability-12-05879
[42] http://www.npc.gov.cn/zgrdw/englishnpc/Law/2007-12/12/content_1383917.htm
[43] https://www.mdpi.com/2071-1050/12/15/5879#B14-sustainability-12-05879

Ашигт малтмалын тухай хууль, Далайн тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Бохирдлоос урьдчилан сэргийлэх тухай хуулиуд зэрэг байна.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙГ ХАРИУЦСАН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

БНХАУ-ын тусгай хамгаалалттай газар түүнд холбогдох асуудлыг хариуцсан төрийн дээд байгууллага нь БНХАУ-ын Экологи, Байгаль орчны яам[44] байна. БНХАУ-ын Экологи, Байгаль орчны яам нь тус улсын Төрийн Зөвлөлийн харьяа экологи, байгаль орчны асуудлыг хариуцдаг гүйцэтгэх засаглалын байгууллага юм. Тус яам нь Төрийн Зөвлөлөөс гаргасан байгаль орчны тухай хууль тогтоомж, журам, бодлого зэргийг хэрэгжүүлж ажилладаг байна.

БНХАУ-ын Экологи, Байгаль орчны яам нь байгаль орчныг хамгаалах, түүнд хамаарах зохицуулалт болон хяналтыг хэрэгжүүлэх, экосистемийг хамгаалах, байгаль орчны стандартыг боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх эрсдэлийн үнэлгээ хийх, уур амьсгалын өөрчлөлтийг хянах зэрэг үндсэн үүргүүдийг хэрэгжүүлдэг байна. Мөн байгалийн нөөц газарт шинжлэх ухааны судалгаа явуулах үйл ажиллагааг зохион байгуулах түүнд холбогдох зохицуулалтыг хийдэг байна.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ЗӨВШӨӨРСӨН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тусгай хамгаалалттай газрыг БНХАУ-ын Байгалийн нөөц газрын тухай журамд зааснаар үндсэн бүс, хамгаалалтын бүс, туршилтын бүс гэж 3 ангилдаг байна[45]. Тухайн 3 бүсэд зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа харилцан адилгүй бөгөөд үндсэн бүсэд тус журмын 27-р зүйлд заасан судалгаа, шинжилгээний ажлаас бусад үйл ажиллагааг хориглосон байдаг байна. Бусад төрлийн шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагаа нь үндсэн бүсийн гадна байрлах хамгаалалтын бүсэд явагдах боломжтой байна. Хамгаалалтын бүс болон туршилтын бүсэд судалгаа хийх, шинжлэх ухааны туршилт явуулах, сургалтын дадлага хийх, тухайн бүс нутагтай танилцах, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах, үнэт болон ховордсон амьтан, зэрлэг ургамлын төрөл зүйлийг гаршуулах, үржүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг байна.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ХОРИГЛОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагааг БНХАУ-ын Байгалийн нөөц газрын тухай журмын 18, 26, 27, 28, 32-р зүйлд тусгасан байна[46].

18 дугаар зүйл. Энэхүү журамд байгалийн нөөц газрыг үндсэн бүс, хамгаалалтын бүс, туршилтын бүс гэж 3 ангилдаг байна. Экосистемд нөлөөлөх нэн ховордсон амьтан, зэрлэг ургамлын зүйл бүртгэгдсэн нутаг дэвсгэрийг үндсэн бүсэд бүртгэж тухайн бүсэд ямар ч байгууллага, хувь хүнийг нэвтрэхийг хатуу хориглоно.

[44] https://www.mee.gov.cn/
[45] http://en.chinaculture.org/library/2008-01/07/content_21464.htm
[46] http://en.chinaculture.org/library/2008-01/07/content_21464.htm

Энэхүү журмын 27 дугаар зүйлд заасан нөхцөл байдлаас бусад шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

26 дугаар зүйл. Бусад хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн тусгай үйл ажиллагаанаас бусад тохиолдолд мод огтлох, мал бэлчээх, ан агнах, загасчлах, ургамал түүх, тариалах, хээр газар өвс шатаах, олборлолт хийх, чулуу цуглуулах, элс ухах зэрэг үйл ажиллагааг хориглоно.

27 дугаар зүйл. Байгалийн нөөц газар болон дархан цаазат газрын хориглосон бүсэд нэвтрэхийг хориглоно. Хэрэв тухайн бүс газарт шинжлэх ухааны ажиглалт, судалгаа хийх шаардлагатай тохиолдолд тухайн тусгай хамгаалалттай газрыг хариуцсан захиргааны хэсэгт өргөдөл гаргаж, засгийн газрын байгалийн нөөцийн хариуцах газраас зөвшөөрөл авна. Үндэсний байгалийн дархан цаазат газарт нэвтрэх тохиолдолд Төрийн Зөвлөлийн байгалийн нөөцийн газрын зөвшөөрөлтэй байх ёстой байна.

Байгалийн нөөц газрын уугуул иргэдийг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтийг тухайн байгалийн нөөц газрын орон нутгийн засаг захиргаа хариуцна.

28 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай бүс, дархан цаазат газарт аялал жуулчлалын болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Шинжлэх ухааны судалгаа, сургалтын дадлага, сорьц цуглуулах зэрэг байгалийн нөөцөд аюул учруулахгүй үйл ажиллагааг тухайн бүс нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг хариуцсан захиргааны байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авсан тохиолдолд хэрэгжүүлнэ.

32 дугаар зүйл. Байгалийн нөөц газар болон тусгай хамгаалалтын бүсэд барилга байгууламж барихыг хориглоно. Байгалийн нөөцийн туршилтын бүсэд байгаль орчныг бохирдуулж, сүйтгэж болзошгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах болон түүнд холбогдох барилга байгууламж барихыг хориглоно. Тусгай хамгаалалттай бүсэд байрлах барилга байгууламж нь бүс нутгаас тогтоосон бохирдлын стандартыг дагаж мөрдөнө. Бохирдлын хэмжээ нь тогтоосон стандартаас давсан тохиолдолд тухайн байгууламжийн үйл ажиллагааг хязгаалах, учруулсан хохиролд нөхөн төлбөр авах арга хэмжээ авна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

БНСУ

- Protected Planet https://www.protectedplanet.net/country/KOR
- Korean protected area in WDPA https://www.env.go.jp/en/nature/asia-parks/pdf/wg3/APC_WG6-19_Sung-gon%20Kim.pdf
- БНСУ-ын Байгалийн цогцолбортгазрын тухай хууль https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=natural+park&x=0&y=0#liBgcolor1
- Natural Environment Conservation Act https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=37572&type=part&key=39
- Enforcement Decree Of The Natural Parks Act https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=natural+park&x=0&y=0#liBgcolor1
- Natural Parks ACThttps://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=natural+park&x=0&y=0#liBgcolor0
- IUCN https://www.iucn.org/our-union/members/iucn-members/korea-national-park-service

Австрали

- Environment Protection and Biodiversity Conservation Act 1999 https://www.legislation.gov.au/Details/C2023C00225
- Environment Protection and Biodiversity Conservation Regulation 2000 https://www6.austlii.edu.au/cgi-bin/viewdb/au/legis/cth/consol_reg/epabcr2000697/
- National Reserve System https://www.dcceew.gov.au/environment/land/nrs#daff-page-main
- Australia’s Strategy for the National Reserve System 2009-2030 https://www.dcceew.gov.au/sites/default/files/documents/nrsstrat.pdf
- Licences and permits https://www.dbca.wa.gov.au/licences-and-permits
- Independent review of interactions between the EPBC Act and the agriculture sector https://www.dcceew.gov.au/environment/epbc/publications/review-interactions-epbc-act-agriculture-final-report
- What’s protected under the EPBC Act https://www.dcceew.gov.au/environment/epbc/our-role/what-is-protected#daff-page-main

Филиппин

- "National Integrated Protected Areas System Act of 1992." https://lawphil.net/statutes/repacts/ra2018/ra_11038_2018.html
- "Expanded National Integrated Protected Areas System Act of 2018" https://chanrobles.com/RA7586.htm
- Department of environment and natural resources https://www.denr.gov.ph/
- Biodiversity management bureau https://bmb.gov.ph/services/

ОХУ

- Тусгай хамгаалалттай байгалийн Тусгай хамгаалалттай байгалийн газрын тухай холбооны хууль https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_6072/
- ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яам http://government.ru/department/48/events/
- ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яам http://government.ru/rugovclassifier/517/main/
- ОХУ-ын Орчин үеийн өндөр технологи Шинжлэх ухааны сэтгүүл https://top-technologies.ru/ru/article/view?id=33192
- IUCN Library System https://portals.iucn.org/library/node/29138.

БНХАУ

- Challenges for Protected Areas Management in China
- https://www.mdpi.com/2071-1050/12/15/5879#B14-sustainability-12-05879
- Ministry of Ecology and Environment of the People’s Republic of China
- https://www.mee.gov.cn/
- Environmental Protection Law of the People’s Republic of China
- http://www.npc.gov.cn/zgrdw/englishnpc/Law/2007-12/12/content_1383917.htm
- Regulations of the People’s Republic of China on Nature Reserves
- http://en.chinaculture.org/library/2008-01/07/content_21464_5.htm